

УЛСТӨРЧИЙН ХӨРӨГ

УЛС ТӨРЧ

ОНЦЛОХ ХУУЛАС

Н.УЧРАЛ ХУУЛЬ ЗӨРЧӨӨД  
БАЙГАА ЮМ БИШ ҮҮ

ХАРВОНИ ЭМ ХЭДЭН АМ.ДОЛЛАРЫН  
ҮНЭТЭЙ ВЭ

II нүүрт

V нүүрт



Гэрэл зургийг Г.АРГУУЖИИ

ҮЗЭЛ БОДОЛ

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ НЭР ДЭВШИГЧЛИЙН ХЭН НЬ ХЭН БЭ

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ


УИХ-ын ээлжит сонгууль болох гэж буйтай холбогдуулан “Монголын мэдээ” сонин хотын тойргуудыг тойрлон цувралаар хүргэж байгаа билээ. Даваа гарагийн дугаартаа нийслэлийн Хан-Уул, Багахангай дүүргийг онцолсон бол өнөөдөр нар зөв эргэн СХД-т нэр дэвшигчдийн талаар дэлгэрэнгүй танилцуулгыг хүргэж байна.

СХД нэр төртэй, хүч, чадалтай бүсгүйчүүдийн тулааны талбар болно

Хүн ам ихтэй, нутаг дэвсгэр нь ч том гэх утгаар нь СХД-т энэ удаад

зургаан мандат олгожээ. Тодруулбал, УИХ-ын 71-76 дугаар тойргууд. Эдгээр тойрогт МАН-аас “Монполимет” группийн Ц.Гарамжав, Монгол Улсын Шадар сайдын зөвлөх асан Н.Учрал, УИХ-ын гишүүн Д.Сумъяабазар, УИХ-ын гишүүн Д.Тэрбишдагва, “Бишрэлт”-ийн Б.Ундармаа, СХД-ийн ИТХ-ын дарга асан Х.Нямбаатар нар Ардчилсан намаас нэр дэвшиж буй СХД-ийн Ардчилсан намын үүрийн дарга Ө.Пүрэвбаатар, УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг, Засаг дарга М.Чинболд, Ерөнхий сайдын зөвлөх Б.Ургамалцэцэг, УИХ-ын гишүүн Ш.Түвдэндорж, Шударга өрсөлдөөний хэмээгддэг О.Магнай нар тулжээ.

Үргэлжлэл нь III нүүрт



Улаанбаатар: ӨНӨӨДӨР

Өдөр +24  
Шөнө +9

## ЗАЛУУ “ДАШ-ЁНДОН”

Дэлгэрэнгүй II нүүрнээс

Тун удахгүй

Давхар давхар сюрприз

MMINFO

САЙД ЯРЖ БАЙНА

## М.ЗОРИГТ: Онгоцны хөдөлгүүрийг нэг нь худалдаж, нөгөө нь худалдаж авдаггүй юм

М.ДУЛАМ

Өнгөрсөн сарын 03-нд Ховдоос Улаанбаатар чиглэлд нислэг үйлдэх ёстой байсан “МИАТ” ХК-ийн “Боинг 737” онгоц нислэгийн зурвасаас гарч, эвдэрсэн. Тэгвэл тус онгоцыг засварлаж дуусчээ. Энэ асуудлын талаар Зам тээврийн сайд М.Зоригттой ярилцлаа

“Ховдын чиглэлд нислэг үйлдэж байсан онгоц зурвасаас гарсан шалтгааныг тодруулах ИНЕГ болон НОЗШША-ны байцаагчийн дүгнэлт гарсан уу?”

“Ховдын чиглэлд нислэг хийж байсан “МИАТ” ТӨХК-ийн “Боинг 737” онгоц Ховдын нисэх буудлын хөөрч буух

зурвасаас хөөрөлт хийх үедээ гаргасан зөрчил юунаас болсон талаархи нарийн дүгнэлт, хариу гарах ёстой. Гэхдээ энэ дүгнэлтийг байцаагч зүгээр нэг гаргачих асуудал биш юм. Хууль дүрмийн дагуу шинжлэн шалгах алба гаргадаг. Алба нь өөрсдийн хэмжээнд гаргадаггүй, онгоцны хөдөлгүүрийг онгоцны

үйлдвэрлэгч орон тайлж уншиж, дүгнэлт гаргадаг учир хугацаа их ордог. Хоёр гурван сарын хугацаа шаардлагатай. Өнгөрөгч өвөл Өмнөговьос Улаанбаатарын чиглэлд нисэх “Аэромонгол”-ын онгоцны хөдөлгүүр унтарсан. Үүний шалтгаан мөн л гурван сар хагасын дараа гарсан. Онгоцонд ямарваа нэг зөрчил гарлаа гэхэд байцаагчийн дүгнэлт гартал нислэг хийхгүй, ашиглахгүй байна гэсэн үг биш юм. “МИАТ” компани засвар үйлчилгээгээ хийгээд, онгоцоо бэлэн болгож олон улсын нислэгт гараад эхэлчихсэн байгаа.

Үргэлжлэл нь IV нүүрт

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд 44 дугаар

Захиалгын үнэ 15400

Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

ХААН банк	Авах		Зарах		Хуудалгаа хөгжлийн банк	Авах		Зарах	
	АМ.ДОЛЛАР	ЕВРО	ИЕН	ФУНТ		АМ.ДОЛЛАР	ЕВРО	ИЕН	ФУНТ
	1984.00	2218.00	18.32	2805.00	1982.00	2169.00	17.84	2814.00	2914.00
	1993.00	2279.00	18.85	2885.00	1993.00	2258.00	18.65	27.93	32.11
				301.00				299.80	303.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар



## УЛС ТӨР

УЛСТӨРЧИЙН ХӨРӨГ

## ЗАЛУУ “ДАШ-ЁНДОН”

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

Уул нь түүний алдар Д.Амарбаясгалан л даа. Харин намынх нь залуучууд МАН-ын залуу Даш-Ёндон хэмээх аж. Нэгэн цаг үед Бүдрагчаагийн Даш-Ёндон гэх эрхэм МАН-ын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан билээ. Зангаргайтай, ноён нуруутай, гүндүүгүй дарга гэдгээрээ бүхий л цаг үед хүлээн зөвшөөрөгддөг энэ эгэлгүй улстөрчтэй Д.Амарбаясгаланг дүйцүүлнэ гэдэг чухамдаа МАН-ын залуучууд ямар их итгэл хүлээлгэдгийн нотолгоо байж мэднэ. Үүнийг нь ч түүний МАН-д хашсан албан тушаалууд нь гэрчлээд өгөх биз. Тэрбээр 27-хон настайдаа НИТХ-д нэр дэвшин нийслэлийн хамгийн залуу гишүүн болж байсан бол хойтон жил нь буюу 28-тайдаа МАН-ын түүхийн хуудаснаа хамгийн залуу газрын дарга хэмээн бичигдсэн байх юм. МАН ууган улс төрийн хүчний хувьд бага залуу гэж голлолгүй итгэл хүлээлгэн хариуцлагатай албан тушаалуудад томилсоор ирсэн нь түүнийг их улс төрдүе шаттайгаар бэлдэж буйн илэрхийлэл гэлтэй. Д.Амарбаясгалан өнгөрсөн дөрвөн жилд НИТХ дахь МАН-ын бүлгийн даргаар ажилласан. Өмнө нь, тодруулбал 2004-2008 онд НИТХ-д төлөөлөгчөөр сонгогдсон нэгэн. Сая хүнтэй их айлын тулах багана болсон улс төрийн хоёр хүчний нэгнийх нь даргын хувьд түмний анхаарал үргэлж түүнийг хараалж байдаг. Эл үүднээс нийслэлийн иргэд, тойргийнх нь сонгогчид НИТХ дахь цөөнхийн бүлгийг сөрөг хүчнийхээ үүргээ хангалттай сайн биелүүлсэн хэмээн дүгнэж байгаагийн цаана ч бүлгийн дарга Д.Амарбаясгалангийн санал санаачилга, хичээл зүтгэл хамт



үнэлэгдэж буй. Монголын нийгмийн болоод нийслэлийн иргэний сайн сайхны төлөө эрх баригчидтай нэг санаа оноотой байж, явуулж буй бодлого үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгч, алдаа гарсан тохиолдол бүрт засч залруулах боломжийг түүний удирдсан баг олгож байсныг хэн ч өнөөдөр мартаагүй байгаа. Ерөөсөө Амарбаясгалан гэх хүний дотоод үзэл бодол нь тийм юм билээ. Тэр ямагт шударга үнэний дуу хоолой болж байдаг. Тэглээ гээд эрх мэдэлтний өмнө толгой гудайлган, номхон зогсоогүй. Бүлгээр нь шүүхэд өгч, буруутан мэт харагдуулж байсан ч үнэн ялсан юм. Амарбаясгалан дарга сөрөг хүчин гээд бүхнийг нөгөө өнцгөөс харж болохгүй гэсэн байр сууриас асуудалд ханддагт нь НИТХ-ын танхимын гишүүд түүнд талархаж явдаг юм билээ. Тэрбээр өөрөө ч Монгол Улсын хөгжил дэвшил, нийслэлийн иргэдийн сайн сайхны төлөө зориулагдсан бүхий зүйлийг сэтгэл, зүрхээрээ дэмждэг, бодлогыг нь хэрэгжүүлэхийн төлөө зүтгэдэг хэмээн нэгэн ярилцлагадаа онцолсон нь бий. Монгол Улсын Ерөнхийлөгч давхар дээлийн асуудлыг анх гаргаж тавихад МАН-ын бүлгийн дарга Д.Амарбаясгалан байртайгаар хүлээн авч мнни парламентийн үйл ажиллагаанд

хэрэгжүүлэхийн төлөө хичээн зүтгэж, НИТХ-ын эхний өдрийн хуралдаан дээр НИТХ-ын төлөөлөгч ч давхар дээлтэй байх ёсгүй хэмээн сөрөг хүчний байр суурийг илэрхийлж байлаа. Үнэндээ 26 гишүүний 24 нь Засаг даргын үйл ажиллагаанаас шууд хамаарал бүхий харьяа агентлаг, газар, хэлтсийн даргаар ажиллаж буй тохиолдолд хөндлөнгийн хяналтыг тавьж чадах нь юу бол. Шулуухан хэлэхэд, амьгүй албатаас ялгаагүй бус уу. Бусдад жижиг мэт санагдаж мэдэх эл асуудал түүнийг НИТХ-ын шинэ төлөөлөгч нарт болоод иргэд, сонгогчид нь улам бүр таниулж өгсөн. НИТХ дахь бүлгийн даргын дөрвөн жилийн турш төмсөн, байр сууриа илэрхийлсэн өөр нэг сэдэв бол Засаг дарга алдаа гаргах аваас ИТХ-ын 45 гишүүний өмнө хариуцлага хүлээдэг байх тогтоолдоог НИТХ-д бий болгох явдал. Үүний үр дүнд Засаг дарга болон эрх баригчдын буруутай олон үйлдэл, үйл ажиллагааг нь олон нийтэд ил болгож чадсан билээ. Нийслэлийн төсвийн хэлэлцэн батлах үед ч цөөнх болоод бүлгийн дарга дуугүй байгаагүй. Төсвийн хөрөнгийг үр ашиггүйгээр зарцуулахын эсрэг баттай зогссон түүний тэмцэл биеллээ олж, олон олон үргүй зардлыг хааж чадсан. Мөн НИТХ-ыг байнгын ажиллагаатай

...Уул нь түүний алдар Д.Амарбаясгалан л даа. Харин намынх нь залуучууд МАН-ын залуу Даш-Ёндон хэмээх аж. Нэгэн цаг үед Бүдрагчаагийн Даш-Ёндон гэх эрхэм МАН-ын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан билээ...

байлгахын төлөө тэр бас багагүй зүтгэснийг, мэрийснийг хэн хүнгүй мэдэж буй. Энэ мэтчилэн хувь төлөөлөгч болоод НИТХ дахь цөөнхийн бүлгийнхны санаачилсан, дэвшүүлсэн, хийсэн ажлыг талархалыг оюулж болно. Түүнчлэн НИТХ-аас гаргасан тогтоолд хориг тавьснаар гарсан үр дүнгийн тухайд ч хэдэн хуудас материал өмнө минь дэлгээтэй байна. Харин улстөрчийн хувьд Д.Амарбаясгалан гэж хэн юм бэ. Хэвлэл, мэдээллийн аль ч хэрэгсэлээр тэрбээр өөрийгөө болоод хувийн амьдралаа дэлгээд

байдаггүй болохоор хувь хүн талаасаа хаалттай юм шиг санагдаж болох ч МАН-ын түүхэн номд залуу үеийн төлөөлөл болон бичигдсэн хэсгээс иш татахад Говь-Алтай аймгийн гаралтай, нийслэлийн иргэн Дашээвэгийн Амарбаясгалан нь 19-хон настайдаа Монголын ууган намтай хувь заяагаа холбожээ. Өөрийн үзэл бодолтой хүүг МАН залуу хүн, гэнэн томоогүй оюутан гэж голоогүй. Харин ч төлөвшиж, бие хүн болохын цагт МАН-ын үйл хэргийг цааш нь үргэлжлүүлэн авч явж чадах хэмжээний боловсон хүчин байж чадна хэмээн итгэл үзүүлж, эгнээндээ нэгтгэсэн нь өнөөдөр хамгийн зөв шийдвэр болох нь харагдаж байна. МАН-ын ахмад гишүүд ч түүнийг дэргэдээ шадарлуулж, улстөрч хүнд байх ёстой бүхий л зан чанарыг түүнд суулгасан нь дамжиггүй. Тэр утгаар нь улстөрчийн болоод хувь хүний төлөвшилийн тухайд ч өөлөх зүйл олддоггүй юм, түүнээс. Нөгөөтэйгүүр, түүний удам судрыг хөөх аваас Амарбаясгалан эцгийнхээ үйл хэргийг залгамжилж яваа хүү. Намын ахмад гишүүн н. Дашээвэг агсан ч бүхий л насаараа намдаа хоёргүй сэтгэлээр зүтгэсэн нэгэн байлаа. Говь-Алтай аймгийнхан энэ буурлыг анддаггүй. “60 жил” хоршооллын намын үүрийн даргаар олон жил ажилласан болохоор нь тэр байх. Шударга үнэн үгтэй, хэлэх гэсэнээ шулуухан хэлчихдэг занг хүү Д.Амарбаясгалан нь өвлөсөн. Тэр ч утгаараа НИТХ-д хоёр удаа сонгогдон найман жил төлөөлөгчөөр ажиллахдаа ямар ч асуудалд өөрийн үзэл бодлодоо үнэнч байж, болж бүтэхгүй үйлдлийн хажуугаар дуугүй өнгөрч байгаагүй юм. Амарбаясгалан итгэл үзүүлсэн нийслэлчүүд ч түүнд дандаа ойр байхыг хичээдэг. Өөрөө ч ялгаагүй. Намын болоод НИТХ-ын төлөөлөгчийн нүсэр ажлын завсар зайгаар иргэдтэйгээ

уулзаж л явах. Амралтын өдрүүдээр гэртээ тогтоно гэж үгүй. Баянхошуу, толгойд, Шувуун фабрик, Налайх, Гацуурт гээд хаана ч түүнтэй тааралдаж болно. Ажлын өдрүүдэд НИТХ-ын Цөөнхийн бүлгийн даргын умгар өрөө өдөржин хүний хөлд дараастай онжих. МАН-ын төв байран дахь ажлын өрөө нь ялгаагүй. Үүдний өрөөнийх нь сандал дээр хэд хэдээрээ болжмор адил зээлэгчхсэн “Амарбаясгалан даргатай уулзах гэсэн юм”, “Өргөдлийн маань харниг шийдэж өгсөнд нь талархлаа илэрхийлэх гээд явж байна, ах нь”, “Хашааны газар хөөлцөлдөөд явж байна. Манай хорооны Засаг дарга Амарбаясгалан төлөөлөгчтэй уулзахыг зөвлөсөн” гээд л хүлээгээд сууж байх. Түүнийг зорьсон иргэдийн цуваа тасрах нь үгүй. Мань хүн ч төвөгшөөсөн шинжгүй уулзалтуудыг ар араас нь хөврүүлсээр суух. Үнэндээ тэр хэн нэгний асуудлыг шийдчихвэл, шийдэх гарцыг нь хэлж өгсөндөө байрлах суудаг сэтгэлийн амьтан билээ. Харин үүнийгээ эцгээс өвлөсөн зан, гэр бүлийн хүмүүжил хэмээн даруухнаар өгүүлдэг. Боловсрол мэдлэгийн тухайд Амарбаясгалан дарга хаана ч, хэнд ч гологдохгүй шинэ цагийн Монгол Улсын чадалтай боловсон хүчнүүдийн нэг. Үндсэн мэргэжил нь холбооны инженер. Дараа нь улс төр судлаачаар боловсролоо АНУ-д ахиулсан байдаг. Улстөрчийн арвин баян туршлагаас гадна бизнес эрхлэгчдийн жаргал зовлон, тулгамддаг асуудлыг нь бие сэтгэлээрээ мэдрэх чадвар түүнд бий. Яагаад гэвэл Амарбаясгалан даргад хэвлэлийн бизнесийг өөд татаж, хөл дээр нь баттай зогсоосон менежерийн ухаан боловсрол хоёр, хоёулаа байдаг. Хоёрыг бодож, нэгнийг тунгаах ухааныг өөрийн болгосон НИТХ-ын төлөөлөгч нийслэлийн хөгжил дэвшлийн төлөө шинийг бодож, тунгааж яваа нь гарцаагүй.

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчлаланы алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## С.Одонтуяа ОХУ-д айлчилжээ

Ж.МЯГМАР

ОХУ-ын Холбооны хурлын Холбооны Зөвлөлийн орлогч дарга Г.Н.Кареловичийн урилгаар УИХ-ын гишүүн, АН-ын бүлгийн дэд дарга, Ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн С.Одонтуяа энэ сарын сарын 3-ны өдөр тус улсад айлчлаад ирлээ. Айлчлалын хүрээнд хоёр улсын нийгмийн хамгааллын салбар дахь хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон бөгөөд Монгол улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Б.Дэлгэрмаа байлцжээ. ОХУ-ын Холбооны хурлын Холбооны Зөвлөлийн орлогч дарга Г.Н.Карелова уулзалтын үеэр ОХУ-ын нийгмийн халамжийн салбарт тулгамдаж буй асуудлууд, төр засгийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар дэлгэрэнгүй танилцуулж Монгол Улстай хуримтлуулсан туршлагаасаа хуваалцах, энэ салбарт хамтран ажиллах боломжтой талаар мэдэгдсэн юм. ОХУ-д “Материнский капитал” буюу “Эхийн дэмжлэг” нэртэй хөтөлбөрийг 2007 оноос эхлэн хэрэгжүүлсэн нь ээжүүд, хүүхдүүдэд хамгийн их ач тусаа өгч байгаа хөтөлбөр болсон байна. Энэхүү хөтөлбөрөөр хүүхдийн тооноос хамаарч ээжүүдэд олгож буй дэмжлэгийг орон сууц, хүүхдийн боловсрол, эрүүл мэндэд зарцуулах боломжийг олгодог байна. УИХ-ын гишүүн С.Одонтуяа санал солилцсон олон асуудлаас “Материнский капитал” буюу “эхийн дэмжлэг” хөтөлбөрийн талаар онцгойлон сонирхож, санал солилцоод иржээ. Дашрамд дуулгахад Г.Н.Карелова УИХ-ын гишүүн С.Одонтуяаг 2015 онд Санкт-Петербург хотноо зохиогдсон Евро-Азийн Эмэгтэйчүүдийн анхдугаар олон улсын чуулга уулзалтад оролцсон талархал илэрхийлж, Уфа хотноо болох ээлжит форумд оролцохыг урьсан байна.

## Хаврын чуулганаар бие даасан 12 хуулийг баталжээ

УИХ-ын хаврын чуулган нийт 45 хоног хуралдаад түр хугацаагаар завсарласан юм. Энэ хугацаанд УИХ бие даасан хууль 12-ыг баталсан бол 98 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Шинэчлэн баталсан хуулиудад хууль эрх зүйн салбарт хамаарах хуулиуд багтаж байгаагийн зэрэгцээ

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай, Хог хаягдлын тухай, Органик хүнсний тухай хуулиуд орж буй аж. Нэмэлт өөрчлөлт оруулсан хуулиудын ихэнх нь Процессын хуулиудтай холбогджээ. Түүнчлэн УИХ-ын хаврын чуулганыг тавдугаар сарын сүүлээр завсарлуулах чиг барьж байсан ч гишүүдийн

ирц тааруугаас тавдугаар сарын 24-нөөс зургаадугаар сарын 23-нийг дуусгах хугацаанд түр завсарлуулах захирамжийг УИХ-ын дарга гаргасан. Иймээс УИХ зургаадугаар сарын 24-нөөс эргэн ажилдаа орж, зайлшгүй батлах ёстой хэвлэлүүдийн шатанд үлдээсэн төслүүдээ батлах ёстой.



## Н.Учрал хууль зөрчөөд байгаа юм биш үү



Э.МӨНХ

Энэ жилийн сонгуульд янз бүрийн хүн нэр дэвшиж буй. Түүний нэг нь Төмөн хэмээх нэрээр гарч ирж байсан Н.Учрал. Эдүгээ тэрбээр “Рояль” Академийн захирал гэх албан тушаалыг хашиж буй бөгөөд Ардын намаас Сонгинохайрхан дүүрэгт нэр дэвшиж байгаа. Тэгвэл тэрбээр сонгуулийн сурталчлалга эхлээгүй байхад аль хэдийнэ сурталчлалгаа эхлүүлж хууль зөрчөөд амжжээ. Тодруулбал, тэр нэр дэвшиж буй дүүргийнхээ хур хогтой хэсэгт очиж баахан “шоуджээ”. Үүнд нь иргэд нэлээд дургүйцсэн бөгөөд

үзэл бодлоо олон нийтийн цахим сүлжээгээр илэрхийлээд амжиж. Үүнд, “Учрал гэдэг нөхөр хогны өмнө очиж зургаа авахуулж байхаар хогийг нь цэвэрлэхчээд явсан бол... Сонгуулийн сурталчлалга эхлэхээс өмнө хогны өмнө очиж байгаад ийм олон хүний бүрэлдэхүүнтэй зураг авалт хийж шоудаж байгаа хүнийг яах ёстой вэ. Энэ хогны өмнө тэрд хэрэгтэй хүнийг сонгох нь дээр шүү...” хэмээн сэтгэгдлээ илэрхийлж, үүнийг нь олон хүн дэмжсэн байна.

## Шинэ нөхцөл дэх эдийн засгийн бодлогыг ярилцана

Монголбанк, БЭСТ консорциум, МУИС-ийн Эдийн засгийн тэнхим хамтран зохион байгуулж байгаа 2016 оны олон улсын эрдэм шинжилгээний хурал энэ сарын 10-ны өдөр зохион байгуулагдах гэж байна. Тус хурал 2014 онд Эрдэс баялгийн орлогын менежмент, 2015 онд Аж үйлдвэрийн бодлого зэрэг ерөнхий сэдвүүд дор зохион байгуулагдаж байсан бол энэ удаад дэлхийн зах зээлийн өөрчлөлтийг даган эдийн засгийн бодлогын онол, туршлагыг танилцуулах, тус чиглэлээр үр дүн болон мэдлэгийг бусдад түгээх зорилгоор “Шинэ нөхцөл дэх эдийн засгийн бодлого: Онол ба бодлого” сэдвийн дор зохион байгуулагдах юм. Олон улсын эрдэм шинжилгээний хурал дараах гурван үндсэн чиглэлээр зохион байгуулагдана.

1. Шинэ нөхцөл дэх мөнгөний ба сангийн бодлого
  2. Монгол Улсад олон салбарын төрөлжилтийг хэрэгжүүлэх бодлого ба асуудлууд
  3. Институдийн орчин ба тогтвортой хөгжил
- Энэхүү хуралд эдийн засгийн бодлогын чиглэлээр ажилладаг төрийн түшээд, ОХУ, Япон болон бусад орны судлаачид, дотоодын их дээд сургуулиудын судлаач нар эдийн засгийн бодлого, бизнесийн нөхцөл, олон улсын жишээ, бодлогын оновчтой шийдлүүдийн талаар төрийн бодлого, санал бодол, судалгааг танилцуулж, бодлогыг хэрэгжүүлэх дэлхийн туршлагыг олон нийтэд түгээж санал солилцох юм.



# ҮЗЭЛ БОДОЛ

## Дугаарын 60 мөр Даалгавраар “далдаганагсад” ичих нүүр алга уу

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Харин 2012-2015 онд буюу сүүлийн гурван жилд 3405 км хатуу хучилттай авто зам барьж, 91 жилийн хугацаанд барьсан авто замаас даруй 441 км-ээр илүү авто замын их бүтээн байгуулалтыг хийсэн гээд бод доо. Одоо ч авто замын их бүтээн байгуулалт өрнөсөөр байгаа. Саяхан Их Монгол Улсын гудамж буюу Замын цагдаагийн баруун урд уулзвараас Маршалын гүүрний урд уулзвар хүртэлх 2.3 км авто замын өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдсэн. Уг ажлын хүрээнд одоо байгаа есон метрийн өргөнтэй зорчих хэсгийг 14 метр болгон өргөтгөж, замын хоёр талаар явган хүний замтай, нэг талаараа дугуйн замтай, гэрэлтүүлэг, борооны ус зайлуулах дэд шугамтай, дөрвөн эгнээ бүхий авто зам болгон шинэчилсэн юм. Гэтэл энэхүү шинэхэн авто замын зургийг 22 жил засч янзлаагүй замын зурагтай харьцуулан тавьж “АСЕМ-ын зам, Ард түмний зам” хэмээн түмний “тархийг угаах” үйл ажиллагаа өрнөөд авсан. Гэтэл “Ард түмний зам” хэмээн нэрлэсний учир юун. Ард түмэн толь шиг замаар явах хувьгүй хэмээн бүдүүлээр доромжилсон нь тийм ч олон хүнд таалагдаагүй. Тэгээд ч 22 жил засаагүй замын буруутан хэн бэ гэдгийг ярих бол урт түүх бичих шаардлага гарах биз. Шүүмжлээд байгаа энэхүү замаар АСЕМ-ын төлөөлөгчид гурав хоног л явна. Явахдаа халааслаад аваад явчихгүй нь мэдээжийн хэрэг. Энэ мэтээр бүтээн байгуулалтын шүүмжлэл дуусахгүй үргэлжилсээр байна. Шүүмжлэгч багийнхан авто замыг нь шүүмжилж дуусаад, явган зам болон дугуйн зам руу орсон. Тодруулбал, өнгөрсөн долоо хоногт олон нийтийн сүлжээгээр зам дээр ургасан модыг тойруулаад ямар ч зайгүй асфальтчихсан зураг тавиад л шүүмжилж гарсан. Гэтэл замын ажлыг гүйцэтгэгч компани замын дагууд таарсан хуучин тэнд байсан амьд модыг аль болох улдээхийг эрмэлзсэн юм билээ. Хэрвээ тэгээгүй шүүмжлээд байгаа хоёр модыг огтлоод л хаячих байсан биз. Харин тэд тэгснгүй.

Тиймээс ч асфальт дэвсгэг машины ажиглах хурд, зөв дэвсэлтийг тооцсоны үндсэн дээр дугуйн замыг барьсны дараа цонхлож хашлага тавихаар төлөвлөсөн байгаа юм. Маргааш нь дугуйн замын дагууд таарсан моднуудыг тойруулж хашлага тавих, тогоо үүсгэж хар шороо цацаж ажлаа гүйцэтгэсэн хэрэг. Гэтэл замын ажил бүрэн хийгдэж дуусаагүй байхад зургийг нь дарж, хийсэн бүтээн ажилыг нь хэд хоног олон нийтийн сүлжээгээр харлуулах шиг л болсон. Даалгавраар “далдаганагсад” оцойж, овойтол хийж бүтээх чадахгүй юм бол компьютерийн ард нуугдаад элдэв цэцэн үг урсгаж, элийрч суухаас ичих цаг нь болсон баймаар юм. Нийслэлд өмнө 20 гаруй жил байтугай 40 гаруй жил засч янзлаагүй зуслангийн замаас эхлээд бүх замыг шинээр тавихыг нь тавиад, засч янзлах боломжтой нь янзалсан. Тухайлбал, хэдхэн хоногийн өмнө Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг, Зайсангийн гудамжнаас Удирдлагын академийн хойгуур “Japan town” орон сууцны хороолол хүртэлх 0.75 км авто зам, Хан-Уул дүүргийн V хороо, Ямаргайт байрлах Хаан банкны салбараас хойш гэр хорооллын дундуур тавьсан хагас км замууд ашиглалтад орсон. Одоо Сонгинохайрхан дүүрэг, Орбитын уулзвараас Толгойтын эцэс, Үйлдвэрчний эвлэлийн гудамж хүртэлх 3.6 км замын ажлыг эхлүүлэхэд бэлэн болгоод байгаа. Сонгинохайрхан дүүргийн иргэд Толгойтын уг замыг шинэчилж өгөх хүсэлтийг олон удаа ирүүлсэн нийслэлийн удирдлагуудад тавьж байсан юм билээ. Юутай ч шүүмжлэл дундуур олон бүтээн байгуулалтыг нүдэнд харагдаж, гарч баригдтал хийж байгаа нь бахархууштай хэрэг биз ээ. Тиймээс хэн гуайн үгүйсгээд, харлуулаад байгаа замыг хийж, дуусгаад “ингээд хийчихлээ очоод хар” гээд “гайхуулж” болох нь сайхан юм. Ер нь ч тэгээд, юм хийдэг хүн л шүүмжлүүлдэг гэдэг уг байдаг шүү дээ. Юу ч хийдэггүй хүнд шүүмжлүүлэх ч зүйл юу ч байх вэ дээ, хөөрхий.

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ НЭР ДЭВШИГЧДИЙН

# ХЭН НЬ ХЭН БЭ



МАХН-ын нэр дэвшигчдийг Цолмон манлайлна

МАХН өөрийн мөрийг хөөж одсон цагаас хойш МАН-ын саналыг хувааж ирсэн түүхтэй. Угсаа гарвал нэгтэй гэдгээрээ тэднийг зарим хүн эндүүрч МАН-ын гишүүн гээд нэрийг нь дугуйлж байсан удаатай. Энэ удаад ч МАХН тус дүүрэгт өндөр ач холбогдол өгч, намын даргын гэргий О.Цолмон тэргүүтэй улстөрчдөө илгээжээ. Г.Бямбасүрэн гэх автын инженер УИХ-ын 71 дүгээр тойрогт МАХН-аас орж ирэв. Тэрбээр олон жил намын ажил хийж байгаа хүн. Анх Октябрын районы МХЗЭ-ийн нэгдүгээр нарийн бичгийн дарга, дараа нь МАХН-ын хорооны хэлтсийн дарга, Улаанбаатар хотын МАХН-ны хорооны арга зүйч, эдүгээ СХД-ийн МАХН-ын хороонд дэд даргаар ажиллаж байгаа аж. Өнгөрсөн дөрвөн жилд БЗД-ийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчөөр ажилласан нэгэн. МАХН болоод МАН-ын ахмад гишүүд л түүнийг таниж мэдэх болохоос залуучуудын тухайд нэр нь ч дуулдаагүй улстөрч юм. Бас нэг улстөрч танигдаагүй хүн бол МАХН-аас “Бизкон” ХХК-ийн ерөнхий захирал, Засаглалыг дэмжих зөвлөлийн тэргүүн, Монголын дотоод аудиториудын институтын тэргүүн Л.Отгонбаяр. Түүний талар мэдээлэл алга. З.Баян-Сэлэнгэ хатагтай мөн л СХД-т нэр дэвшинэ. Агтай, одтой хүнийг нэрлэх хэрэг гарвал хамгийн түрүүнд Барилга, хот байгуулалтын сайд санаанд буух бий. Улстөрчид түүнийг оймсонд хавчуулагдсан нохор хэмээдэг ч тэрбээр өнгөрсөн дөрвөн жилд бас ч гэж чамлахааргүй улстөрч болж хувирсан.

Цойлсон нь юу л бол. Тэгээд ч тамирчид сургуулийнхаа нэр хүндийг сайн гаргах аваас тэгс хийж байгаад төгсчихдөг юм хойно. Ер нь бөхчүүд Манжийн үеэс хор найруулж сурсан улс байдаг. Дандаа хүнээс юм авдаг болохоор бусдад гар сунгаж, буян үйлдээд байдаггүй зантай. Сумьяагийн хувьд бусдаас авах шаардлагагүй ч өгч байна, буян үйлддэг гэж дуулаагүй. Ийм нэг бөхчин, улстөрч СХД-т дахин нэр дэвшиж байгаа юм байна. Түүний өөдөөс Ардчилсан нам дүүргийн Засаг дарга М.Чинболдыг тавьжээ. Хүүхдийн гэмээр гэнэн хонгор зантай болохоос бий түүнийг хий гээд тавьчихсан байхад ард нь гарахын төлөө зүтгэдэг сайн талтай нэгэн. Улстөрчийн хувьд алдсан нь бий л байх, оносон нь ч бий. Гагцхүү оносон их учраас дүүргийн иргэд түүнд сайн байдаг биз ээ. Ямартай ч дүүргийнхээ төсвийг дэмий зүйлд үрээгүй. СХД өнөөдөр гэрэлтүүлэгтэй, замтай болсон байна лээ. Өмнө нь тас харанхуй ертөнц ноёлсон, хур хогондоо дарагдсан тийм л дүүрэг байсныг санаж байна. Одоо түүнийг санах хүн бараг л байхгүй биз. Ингэж л тэрбээр дөрвөн жилийн хугацаанд дүүргийнхээ өнгө зүсийг өөрчилж чадсан юм. Гэхдээ СХД-г хийх ажил зөндөө. Ядаж л захиргааныхаа навстар байшингаас салах цаг болсон.

Ш.Түвэндорж очиж буй. Тэрбээр уул нь цэргийн хүн. Үндсэн мэргэжил нь холбооны инженер. Дараа нь “Отгонтэнгэр” сургуулийг хуульч, өмгөөлөгч мэргэжлээр төгсч, хууль зүйн ухааны доктор зэрэг хамгаалсан. Түүний ажлын гараа салаан захирагчаар эхэлсэн ч цагаан морин жилийн хувьсгал гарахад МоАХ-ны анхдугаар их хурал болон, Монголын Ардчилсан нам байгуулагдахад тэрбээр гишүүнээр элссэнээр улс төрд хөл тавьсан байдаг. Тэрбээр өөрийгөө АН-ын алтан хараацайнуудын нэг гэж хэлдэг. 1990 оны Ардчилсан хувьсгалд ч гар бие оролцож явсан нь үнэн л дээ. 1992 оноос АН-ын удирдах зөвлөлд тасралтгүй ажилласан. АН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын ажилыг хүрэнх гүйцэтгэж байв. Тэрбээр Ардчилсан нам доторхи МОАХ фракцид харьяалагддаг. Ш.Түвэндорж 1999-2000 онд буюу нэг жил гаруйн хугацаанд БХЯ-ны сайдаар ажиллаж байв. Түүнчлэн 2000 оны сонгуулиар АН-аас Баянзүрх дүүрэгт нэр дэвшсэн ч ялагдсан. ЗГХЭГ-ын дэд дарга, МОАХ-ны гүйцэтгэх захирал, Ардчилсан намын Нийслэлийн даргын албыг тус тус хашиж байсан. 2012 оны сонгуулиар УИХ-ын гишүүнээр сонгогдон эдүгээ Хуульзүйн байнгын хорооны даргаар ажилладаг. Гэхдээ түүнийг байнгын хорооньхоо даргын ажлыг муу хийдэг гэж гишүүд хэлдэг.

УИХ-ын 74 дүгээр тойрогт МАН “урвагч” Д.Тэрбишдавыг илгээжээ. Түүнийг МАХН-ын дарга Н.Энхбаяртай хөтлөцөөд гүйж явсныг нь түмэн мэднэ. Харин эдүгээ нүүр буруулан. Бараг л Энхбаяр гэвэл “танихгүй, тийм хүн байсан бил үү” гэж мэднэ. Мань эр жагсаалтаар дахин УИХ-д гарна гээд тойргоо тас мартчихсан явснаа асуудал бишдэнгүүт аргагүйн эрхэнд очсон. Үнэндээ түүний нэрээр овоглогдож ажил тус дүүрэгт ганц ч байхгүй. Боловсрол мэдлэгийн тухайд бол нэр дэвшигчдийн дотроос чадалтай нь багтана.

Харин УИХ-ын 76 дугаар тойрогт МАН дүүргийн ИТХ-ын дарга Х.Нямбаатарыг явуулжээ. Түүнийг сайн мэдэх хүмүүс зайтай ч лайтай ч эр гэх юм билээ. Паянтай л нөхдүүдийн нэг гэнэ лээ. Өнөө алдартай хар жагсаалтад мань эрийн нэр цохиж явна лээ. Төсөл болон газрын асуудалтай холбогдож, нэрээ сэвтүүлсэн тухай мэдээлэл нь цахим ертөнцөөр дүүрч. Бас ханлилаагүй нэгэн байж мэдэхээр. СХД-ийн удирдлагууд бүгдээрээ л гадаад явсан атулаа Засаг дарга нь лайг нь үүрч, аялсан зугаалсан гэж бичигдэж, мань эр яваагүй, зугаалаагүй юм шиг нэр цэвэр үлдэнэ гэч. Тэрбээр Хэнтий аймгийн гаралтай.

Ардчилсан намаас тус тойрогт өрсөлдөж буй Б.Ургамалцэрлэгийн хувьд улс төрийн өндөр боловсролтой, манай улсын лидер бүсгүйчүүдийн нэг. Боловсролын дэд сайдын ажиллаж байсан. Тэрбээр МУБИС-д сурган, сэтгэл судлалын багш мэргэжлээр суралцаж төгссөн. Мөн Удирдлагын академийг төрийн удирдлагын менежерээр, АНУ-ын Коннектикут мужийн Бридж Фортын их сургуульд боловсролын магистр зэрэг хамгаалсан. Хашсан албан тушаалын хувьд 1996-2001 оны хооронд МСДН-д улс төрийн ажилтан, УИХ-ын гишүүний бие төлөөлөгч, Тамгын газарт мэргэжилтэн, 2007-2008 онд АН-ын Бодлогын зөвлөлд улс төрийн ажилтан, 2008-2012 онд АН-ын нарийн бичгийн дарга, Хүний хэлтсийн даргаар ажилласан. АН-ын нарийн бичгийн дарга, Хүний нөөцийн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа “Монгол хүн-2020” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ҮЗХ-ны гишүүдээс бүрдсэн “Ажилтай орлоготой Монгол хүн”, “Аюулгүй орчинтой Монгол хүн”, “Эрх чөлөөтэй Монгол хүн”, “Эрдэм боловсролтой Монгол хүн”, “Эрүүл чийрэг Монгол хүн” гэсэн таван дэд ажлын хэсгийг ахлан нэг жилийн дотор 21 аймгийг тойрон ажилласан. Б.Ургамалцэрлэг нь Ардчилсан намын “Сум-330 тэтгэлэгт хөтөлбөр”-ийг анх санаачилж хэрэгжүүлсэн нэгэн.

Х.Нямбаатар 1996-2002 онд Орхон Их сургуульд, 2006-2008 онд Цагдаагийн академид /Хууль сахиулагчын Их сургууль/, 2008-2012 онд Удирдлагын Академид сурацаж төгсчээ. Хуульч, боловсрол судлаач мэргэжилтэй, хууль зүйн ухааны магистр, Төрийн удирдлагын докторант зэрэгтэй. Орхон Их сургуульд дуурийн салбар шинээр нээгдэхэд багшаар ажиллах болсноор түүний ажлын гарааны эхлэл тавигджээ. Харин СХД-тэй хувь заяагаа холбосон нь 2009 он. СХД-ийн ЗДТГ-т мэргэжилтэн, хэлтсийн дарга, даргын үүрэгч гүйцэтгэгч, дараа нь 2012 оноос ИТХ-ын дарга гэх мэтчилэн шат дараатай төрийн албыг хашжээ. СХД-ийн Улаан загалмайн нийгэмлэгийн тэргүүн, НАМЗХ-ны холбооны дарга, МАН-ын дэд дарга, тэргүүлэгч, ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгчийн сонгуульд ажилтай.

Б.Ундармаа. Энэ бүсгүйн өвөг “Бишрэлт” болж хувирсан. Таньж мэдэх хүмүүс цагаан гартай л гэгцгээх юм билээ. Нийслэлийн 24 дүгээр сургуулийн сурагч тэрбээр Москвад тэр үеийн Удирдлагын дээд сургуулийг инженер, эдийн засагч, удирдлага зохион байгуулалт мэргэжлээр төгссөн. Дэд сайдад хүртэл нэр нь дэвшигдэж, Монголын хөрөнгийн биржийн захиралд хүртэл яригдаж байсан гэхээр намдаа үнэлэгддэг хүний шинж байх. Цахим ертөнц рүү өнгийхөд түүний талаархи сайн, муу бүхий л мэдээллийг уншиж болно. Хэрхэн дүгнэх нь сонгогч таны эрх. “Хулхи” гэж хүртэл хэлүүдсэн л байна лээ. Түүнийг МАН УИХ-ын 75 дугаарт тойрогт илгээжээ. Мөн энэ тойрогт УИХ-ын гишүүн

Энэ эрхэмтэй О.Магнай учраад байгаа. Монголын ард түмэн түүнийг Иргэний Хөдөлгөөний удирдагч, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга гэдгээр нь анддаггүй.

О.Магнай нь МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулийг 2002 онд, МУИС-ын Хууль Зүйн Сургуулийг 2004 онд тус тус төгссөн, эрх зүйч эдийн засагч мэргэжилтэй. 2002-2005 Санхүү, Эдийн Засгийн яаманд мэргэжилтэн, 2005-2007 “Эрүүл Нийгэм - Иргэний Хөдөлгөөний Ерөнхий Зохицуулагч”, 2007 онд ИЗН-ын ХЭГ-ын даргаар 12 сар ажилласан байдаг. Иргэний Хөдөлгөөн Намын дэд даргын албыг мөн хэсэг хугацаанд хашсан. Түүний улстөрчийн түүх сонирхолтой. УИХ-ын 2008 оны сонгуулийн дараа болсон долдугаар дугаар сарны нэгний үймээнтэй холбогдуулан түүнийг цагдан хорьсон. Тэрбээр хоригдож байх хугацаандаа хуурай өлсгөлөн зарлаж байсныг нь хэн бүхэн мэддэг. Үүнийхээ дараа Ардчилсан намд элссэн юм.



# УЛС ТӨР

САЙД ЯРЬЖ БАЙНА

## М.Зоригт

Төгсгөл. Түүрүүч нь I нүүрт

Энэ бүх асуудал ИНЕГ-ын дүрмээр зохицуулагддаг асуудал юм.

**-Онгоцны хөдөлгүүрийг солихын тулд таван сая ам.долларын зардал гаргаж, хөдөлгүүр худалдаж авсан гэсэн яриа гараад байгаа?**

-Онгоц зурвасаас гарч шороон зам руу орсон учир хөдөлгүүрт тоос, шороо ихээр хуримтлагдсан. Онгоцны хөдөлгүүрийг задалж засч, цэвэрлэх ажлыг үйлдвэр нь хариуцаж байгаа. Бид энэ хооронд нислэгээ хэвийн үргэлжлүүлэхийн тулд гаднаас онгоцны хөдөлгүүр түрээсэлсэн. Хүмүүсийн яриад байгаа таван сая ам.доллараар худалдаж авсан асуудал байхгүй. Сонгууль дөхсөнтэй холбоотойгоор хүмүүс аливаа асуудлыг хэт улстөржүүлээд байна. Таамаглаад, зохигоод биччих юм. Дэлхийн аль ч орны авиакомпанид онгоцны хөдөлгүүрийг нэг нь худалдаж, нөгөө нь худалдаж авсан түүх байхгүй. Харин сүлжээгээр богино болон урт хугацаагаар түрээсэлж явдаг зүйл. Дэлхийд байхгүй ийм зүйлийг ярьж, үндэсний агаарын тээвэрлэгч байгууллагынхаа нэр хүндийг унагаж болохгүй биз дээ.

**-Ховдын нислэг цаашид хэвийн үргэлжлэх үү?**

-Улаанбаатар Ховд чиглэлийн "Боинг 737" онгоцны нислэг цаашид хэвийн үйлдэгдэнэ. Энэ дашрамд хэлэхэд МИАТ-ийн нэг "Боинг" онгоцны нислэгийн хугацаа дууссан учраас графикайн дагуу нислэг хийх өөр "Боинг" агаарын хөлгөө сая авчирлаа. Одоо МИАТ компанийн онгоцны хүрэлцээ хангалттай болсон.

**-“Боинг 737” онгоц зурвасаас гарч, хөдөлгүүр гэмтсэнээр МИАТ компанид хэдий хэрийн хохирол учирсан бол?**



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

### ОНГОЦНЫ ХӨДӨЛГҮҮРИЙГ НЭГ НЬ ХУДАЛДАЖ, НӨГӨӨ НЬ ХУДАЛДАЖ АВДАГГҮЙ ЮМ

-Онгоц зурвасаас гарсан асуудал нь нэлээд ноцтой осол, зөрчилд тооцогддог. Гэхдээ даатгалтай байдаг учраас бүх зардлыг даатгалаас хариуцан гаргаж байгаа. Журам нь ч тийм. МИАТ хохирсон асуудал байхгүй.

**-Нисэх буудлын 49 метрийн өргөнтэй зурваст нислэг үйлдэх, 36 метрийн өргөнтэй зурваст нислэг**

**үйлдэх хоёрын хооронд ямар ялгаа байдаг юм бол. Тусдаа журам, стандарт байдаг уу?**

-Стандарт байлгүй яах вэ. Олон улсад мөрдөгддөг стандарттаар 35 метрээс дээш бол "Боинг 737" онгоц хүлээж авна, хөөрч бууж болно. Ховдын нисэх буудлын зурвас 35 метрийн өргөнтэй байгаа нь олон улсад ч зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, стандарт. МИАТ

компани зуны улиралд олон захиалгат нислэг хийдэг. Ихэнх хотын аэродром 35 метрийн өргөнтэй байдаг. "Боинг 737" бол дэлхий дээр хамгийн олон үйлдвэрлэгдсэн онгоц. Энэ онгоцны стандартад тохирсон зам дэлхий дээр хамгийн олон байгаа.

**-МИАТ, "АэроМонгол" компаниудын хооронд хийсэн гэрээгээр бол МИАТ компани Ховд руу энэ сарын 15-ныг хүртэл нислэг үйлдэнэ. "Аэромонгол" компанийн шинэ онгоц энэ**

дээр нь үндэслэн хамтарч шинэ агаарын хөлөг авах гэрээ хэлэлцээрээ хийгээд байна. Харин хоёр компани болон онгоц түрээслүүлж байгаа талын нөхцөл, шаардлагаас хамаараад хугацаа хойшилж болох юм.

**-Хугацаа хойшилбол ямар нэг алдагдал хүлээх үү, манай тал?**

-Тийм зүйл байхгүй ээ. Манай ИНЕГ эдийн засгийн зохицуулалтыг нь хийгээд өгчихсөн. Энэ бол маш том зохицуулалт. МИАТ компанид ч ямар нэг алдагдал хохирол байхгүй.

**-Агаарын тээврийн салбартай холбоотой бас нэг яриаг тодруулъя. Хөшигийн хөндийд баригдаж буй шинэ нисэх буудлыг олон улсад хүлээн зөвшөөрөхгүй байна гэсэн мэдээлэл гарсан?**

-Тийм зүйл байдаггүй л байхгүй юу. Олон улсын нислэг үйлдэж байгаа, олон улсын нислэгт үйлчилж байгаа нисэх буудалд олон улсын байгууллагаас код өгдөг. Дөрвөн оронтой тоо, үсэгнээс бүрдсэн цифр өгдөг. Энэ код нислэгийн хуваарь, төлбөр тооцоонд зориулагдсан байдаг. Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд тэр кодыг авах шаардлага одоогоор байхгүй. Бүр тодруулбал, манай улсаас хүлээн зөвшөөрүүлэх ямар нэгэн хүсэлт гаргасан байх шаардлагатай болно. Гэтэл манайх тийм зөвшөөрөл хүссэн зүйл байхгүй. Хүмүүсийг төөрөгдүүлсэн ийм яриа гаргаж байгаа нь харамсалтай. Аль ч улс, хэн ч бай хувийн компани, хувь хүн ч нисэх буудал бариад аэродром байгуулж болно. Гол нь олон улсын чанарын шаардлага, аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангаж байвал асуудалгүй. Харин Хөшигийнхөндийн нисэх буудал ашиглалтад ороход гэрчилгээ олгох ёстой. Энэ гэрчилгээг олон улсын байгууллагаас биш манай ИНЕГ-аас аюулгүй ажилгааны дүрэм, стандартын шаардлага хангасан барилга, байгууламж болжээ гэж үзвэл гэрчилгээ олгоно. Ийм л юм. Гэхдээ мэдээж ганц барилгын асуудал биш ажилчдын ур чадвар, мэдлэг, ажилчдын зөвшөөрлийг харгалзан үзэж байж гэрчилгээ олгодог.

**-Хөшигийн хөндийн олон**

**...“Боинг 737” онгоц зурвасаас гарч, хөдөлгүүр гэмтсэнээр МИАТ компанид хэдий хэрийн хохирол учирсан бол?**

**-Онгоц зурвасаас гарсан асуудал нь нэлээд ноцтой осол, зөрчилд тооцогддог. Гэхдээ даатгалтай байдаг учраас бүх зардлыг даатгалаас хариуцан гаргаж байгаа. Журам нь ч тийм. МИАТ хохирсон асуудал байхгүй...**

**хугацаандаа багтаж ирж, Ховдын нислэг саадгүй үргэлжилж чадах болов уу?**

-Ховд руу нислэг үйлдэж байсан МИАТ-ийн онгоц техникийн саатлаас болоод түр зогсчихлоо. "Аэромонгол" компани МИАТ компанигай хамтран "Боинг 737" онгоц түрээслэхээр оруулж ирэх гэж байна. Бэлтгэл ажил нь хангагдсан. Манай МИАТ компани олон жил олон улстай хамтран ажиллаж, онгоц түрээсэлж байсан арвин туршлагатай. Энэ туршлага

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Ерөнхий сайд Ротари байгууллагын ерөнхийлөгчидтэй уулзлаа

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Олон улсын Ротари байгууллагын Ерөнхийлөгч, ноён К.Р.Равиндран тэргүүтэй төлөөлөгчдийг өчигдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтаар Монгол Улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Ротари клубууд нийгмийн төрөл бүрийн чиглэлээр хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй төслүүдийн үр дүнд Засгийн газар талархаж байдгийг онцлон тэмдэглээд олон улсын ротаричуудын сайн санааны үйлсийг цаашид ч манай төр, засгийн байгууллагууд дэмжих болно гэлээ.

Одоогийн байдлаар Монголд 16 Ротари клуб үйл ажиллагаа явуулж, эрүүл мэнд, боловсрол, эх нялхсын эрүүл мэнд, байгаль орчин, цэвэр ус зэрэг чиглэлээр олон арван төсөл хэрэгжүүлж, үр шимийг нь манай олон мянган иргэн хүртээд байгаа юм байна. Ротари клубуудын Монгол дахь үйл ажиллагаатай танилцахаар манай оронд хүрэлцэн ирээд байгаа Шри Ланка улсын иргэн, ноён К.Р.Равиндран Олон Улсын Ротари байгууллагын 2016 оны Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байгаа бөгөөд Олон улсын Ротарийн дээд чуулган Сөүл хотноо өнгөрсөн долоо хоногт амжилттай зохион байгуулагдсан билээ.

## Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хууль хэрэгжиж эхлэв

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хүлээн авах хүндэтгэлийн үйл ажиллагаа Төрийн ордонд боллоо. Тус үйл ажиллагаанд УИХ-ын дарга З.Энхболд, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Д.Батцогт, Эрүүл мэнд, спортын сайд С.Ламбаа, гишүүн С.Одонтуяа, Ё.Отгонбаяр болон эрүүл мэндийн салбарынхан оролцлоо. Уг хуулийг анх С.Одонтуяа нарын гишүүд 2015 оны арванхоёрдугаар санаачлан, УИХ-д өргөн мэдүүлсэн ч эрүүл мэндийн салбарын засаглал, санхүүжилтийн томоохон асуудлыг шийдвэрлэх тул Засгийн газраас өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэн, авторыг нь өөрчилсөн юм.

Харин Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн төслийг эх барьж, батлах хүртэл тулж ажилласан багийг гишүүн С.Одонтуяа ахалжээ. Тус хуулийг өнгөрөгч дөрөвдүгээр сарын 22-нд баталсан ч энэ сарын 3-наас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлж буй юм. Энэ үеэр уг хуулийг батлуулахад идэвх, санаачилга гаргасныг уг үнэлж гишүүн С.Одонтуяаг эрүүл мэндийн салбарын хүндэт дэвтэрт бичиж, гэрчилгээ олгосон бол Д.Батцогт, Ё.Отгонбаяр болон бусад хүнийг салбарын тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагналаа.



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

## ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО ХАР ЖАГСААЛТАА ЗАРЛАВ

Б.САРНАЙ

Монголын Залуучуудын Холбооноос өчигдөр "Хар жагсаалтад орсон этгээдийг бүү сонго" хэмээх нэрийн дор хурал зохион байгууллаа. Тус хурлыг зохион байгуулсан Монголын Залуучуудын Холбооны ерөнхийлөгч А.Мөнхбат хэлэхдээ "Монголын Залуучуудын холбоо V их хурлын үеэр төрийн босгыг өндөрсгөө, улстөрчдийн болчимгүй үйлдлийг зогсоё гэсэн үүднээс "Хулгайчгүй Монгол" хөдөлгөөнийг эхлүүлэхээр болсон. Энэ үеэс эхлэн хар жагсаалтыг хэрхэн гаргах, ямар цензур тавих, хэн гэдэг хүн орох, хэдий хугацааг хамруулах зэргийг судалж эхэлсэн. Тэгээд С.Зориг агсны амь насаа алдсан өдрөөс хар жагсаалтыг нэрлүүлэх

үйл ажиллагаа эхэлсэн юм. Бид гурван удаа материал гаргасан. Үүнд, "Хулгайчгүй Монгол" сонин, дараагийнх нь иргэд өөрсдөө нэрлэсэн "100 хар үйлдэл", сүүлийнх нь "Хар жагсаалт" гэв.

1992 оноос хойш 2016 оны УИХ, орон нутгийн сонгуулийн өдөр хүртэл үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндсэн хууль, хүн амын эрх ашиг, хүрээлэн буй орчин, нийтийн үнэт зүйлд харшилсан голлох үйл явдлыг нэрлүүлж 100 хар үйл явдлыг иргэдийн санал дээр үндэслэн гаргажээ. Тодруулбал, залуу гэр бүлийн 500 мянга, Эх орны хишиг, Үнэ тогтворжуулах хөтөлбөр, Хүүхдийн мөнгө тэтгэвэр тэтгэмж, Өршөөлийн хуулийн хориг, Төрийн албаны хямрал, Тендерийн хууль, Хувьчлалын асуудал, Ядуурлыг бууруулах сангийн хөрөнгө, Хадгаламж

зээлийн хоршоодын хэрэг, Боловсролын салбарын шинэчлэлүүд, Түүхийн дурсгалт зүйлийн наймаа, Ноён уулыг хөндсөн нь, Дэд бүтэц шугам сүлжээ, Боловсролын салбарын шинэчлэлүүд, "Цэвэр агаар сан", "Нүүрс хөтөлбөр", Барилга дээр гарсан ослууд, Байгалийн бохирдол хог хаягдал зэргийг багтаан үзжээ.

Үүний дараа олон нийт хүлээн зөвшөөрсөн 100 хар үйл явдлын жагсаалтад оролцсон, гүйцэтгэсэн, зохион байгуулсан этгээдүүдийг нэрлэх, УИХ болон орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлж болохгүй этгээдүүдийн хар жагсаалтыг гаргасан байна. Тэрбээр "Энэ хар жагсаалтад багтсан хүмүүсийг сонгуульд оруулахгүй байх саналыг бүх намын дарга нарт тавьсан боловч авч хэрэгсээгүй.

улсын нисэх буудлын хувьд үнийн тохируулга ямар шатандаа явж байна. Хаана очоод гагцхисан юм бэ?

-Хөшигийн хөндийд баригдаж буй олон улсын нисэх буудлын төсөл бол Япон улсын зээлийн хөрөнгөөр хийгдэж байгаа том төсөл. Сангийн ямаар дамжиж хөрөнгө нь цаг хугацаандаа орж ирж байгаа. Зээлийн хэлэлцээртэй холбоотой тухайн жилийн инфляц, эдийн засгийн чадамж, барилгын материалын үнийн өсөлт зэргээс шалтгаалаад үнийн тохируулга хийгддэг. Энэ асуудал бол хууль, эрх зүйн хүрээнд хийгдээд явж байгаа. Шинэ нисэх буудлын бүтээн байгуулалтын ажил төлөвлөсөн хугацаанаас 5-6 хувийн илүү гүйцэтгэлтэйгээр явж байгаа. Нөгөөтэйгүүр улсын төсвийн хөрөнгөөр баригдах барилгын ажлууд ч эхэлчихсэн. Үнийн тохируулгын асуудлыг Засгийн газар анхааралдаа авсан. Түүнчлэн эрчим хүчний дэд бүтэц, станцыг Монголын талын хөрөнгөөр барьсан боловч гүйцэтгэгч компани гэрээнд заасан хугацаандаа барьж чадаагүй. Үүнээс үүдэн шинэ нисэх буудлын барилгын ажлыг төвийн эрчим хүчний системээр хангах асуудал хойшлогдсон. Оронд нь дизель станц ажиллуулсан. Үүний түлшний үнийн зөрүү тэрбум төгрөг гарчихаад байна. Үнийг гэрээт хугацаандаа ажлаа гүйцэтгээгүй компани хариуцаж төлөх ёстой.

**-Тухайн компанид энэ төлбөрийг барагдуулах талаар шаардлага хүргүүлсэн үү?**

-Мэдээж хүргүүлсэн. Бид хийх ёстой зүйлээ хийсэн гэх байдлаар хандсаар хоёр жил гаруй хугацаа өнгөрсөн байна. Хэрэв төлөхгүй бол хууль шүүхийн байгууллагад хандана.

**-Хөшигийн хөндийн хурдын замын ажил ямар шатандаа яваа вэ?**

-Хөшигийн хөндий рүү Монголд анх удаа хурдны зам тавьж байна. Нийт 32 км замын шавыг тавьсан. Хятадын компани гүйцэтгэгчээр нь ажиллаж байгаа. Харин гүйцэтгэгч компани нь ажлаа төдийлөн сайн жигдрүүлээгүй байна. Ажлаа эрчимжүүлэхгүй бол хариуцлага тооцно гэдгээ санууллаа.

Тиймээс Монголын ард түмэн минь энэхүү хар жагсаалтад багтсан хүмүүсийг сонгохгүй байхыг хүсч байна.

**Тухайлбал:**

- Баянзүрх дүүрэг**  
50-р тойрог МАН-ын нэр дэвшигч Ж.Энхбаяр
- 51-р тойрог АН-ын нэр дэвшигч Д.Пүрэвдаваа

- Хан-Уул, Багахангай дүүрэг**  
58-р тойрог АН-ын нэр дэвшигч Г.Батхүү
- 60-р тойрог МАН-ын нэр дэвшигч Ц.Мөнх-Оргил
- 61-р тойрог МАН-ын нэр дэвшигч Сү.Батболд

- Чингэлтэй дүүрэг**  
63-р тойрог АН-ын нэр дэвшигч С.Дэмбэрэл

- Баянгол дүүрэг**  
68-р тойрог МАН-ын нэр дэвшигч Ж.Ганбаатар
  - Сонгинохайрхан дүүрэг**  
73-р тойрог МАН-ын нэр дэвшигч Д.Сумъяабазар
  - 74-р тойрог МАН-ын нэр дэвшигч Д.Тэрбишдаваа
- гэх мэтчилэн хүмүүс хар жагсаалтад багтсан байна. Мөн УИХ, орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлж болох "Цагаан жагсаалт"-ыг хариуцлагын гэрээн дээр үндэслэн хийсэн бөгөөд энэ сарын 11-нд зарлана. Хэрвээ хэн нэгэн гомдолтой байвал гомдлоо гаргаад яв. Бид хариуцлагаа хүлээх ёстой эрх бүхий байгууллага" хэмээн ярилаа. УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлэхгүй байх хар жагсаалтад багтсан орхмуудийн олонхи нь нэрийн дарга нарт тавьсан боловч авч хэрэгсээгүй.



# ОНЦЛОХ ХУУДАС

## ХАРВОНИ ЭМ ХЭДЭН АМ.ДОЛЛАРЫН ҮНЭТЭЙ ВЭ

### Эсрэг тэсрэг байр суурь

**Ж.Амарсанаа:**  
Хуульгүй гүтгэж  
болдог гэж  
бодож байгаа бол  
эндүүрч



/Эрүүл мэндийн дэд сайд асан/

-Сонгуультай холбоотойгоор миний нэр хүндэд халдах увайгүй оролдлогууд явж л байна. Бодвол энэ ард түмэнд хэрэгтэй ганц хоёр ажил хийчихсэн юм байлгүй дээ. Та нар хүсээд байгаа үр дүндээ хүрэхгүй ээ. Сонгууль болохоор л хүнийг хуульгүй гүтгэж болдог гэж бодож байгаа бол том эндүүрэл. Эхнийх нь надаар оролдож байгаад гурван шатны шүүхээр ялагдчихаад сууж байна. Би амнаасаа гарч байгаа хий болгоноо сайтар бодож тунгааж гаргадаг юм шүү. Үйлдэл бүрээ баримтжуулдаг юм. С вирусын эмийг Монгол Улсад оруулах ажлыг би Засгийн газрын дүрэм журмын дагуу гүйцэтгэсэн. Азаар энэ албан бичгийн хуулбар нь Гадаад харилцааны яам дээр үлдсэн байна. Би 100 хувь өөрөө санаачилж энэ ажлыг хийсэн юм. Зөвхөн монгол хүний эрх ашгийн төлөө хийгдсэн ажил. Амагж байна. Монголын ард түмэн тэнэг биш ээ. Хар цагаан, үнэн худлыг ялгадаг болсон. Харин надад хэн нэгэнтэй гавьяа булаацалдаад байх шаардлага надад байхгүй. Өвчтөн маань үхлийн өвчнөөс салж л байвал надад том шагнал. Харин энэ алга дарам цаас намайг хамгаалаад зогсохгүй Монголын эрүүл мэндийн салбарт гайхамшиг авчрах заяатай байжээ. Яг үнэнийг хэлэхэд тухайн үед том улстөрчдөөс Ц.Элбэгдорж Ерөнхийлөгчөөс бусад нь олигтой дэмжээгүй гэдгийг харин онцлоод хэлчихье. Юу үнэн тэр үнэн.

...Сонгууль болохоор л хүнийг хуульгүй гүтгэж болдог гэж бодож байгаа бол том эндүүрэл. Эхнийх нь надаар оролдож байгаад гурван шатны шүүхээр ялагдчихаад сууж байна. Би амнаасаа гарч байгаа хий болгоноо сайтар бодож тунгааж гаргадаг юм шүү...

...Ж.Амарсанаа “Чи юу гэж хүний бизнесийг булаагаад байгаа юм. Чи ер нь юу хийсэн юм бэ?” гэж давшилсан. Ингэж бид хоёр жаахан онцгүй салсан. Өглөө нь над руу уучлал гуйсан мессэж явуулсан байсан. Одоо ч надад тэр мессэж нь бий...



**Д.Наранбаатар:**  
Ж.Амарсанаа намайг  
хэзээ ч тас цохиж  
чадахгүй

/ОНОМ сангийн ТУЗ-ийн дарга/

-Манай “Оном” сан 2013 онд Монголд элэгний цогц судалгааг хийсэн юм. Монголд 200 мянган хүн элэгний өвчлөлтэй гэж гарсан. Энэ судалгаагаа Монголын эрдэмтэдээ танилцуулахдаа Ж.Амарсанааг урьсан. Ж.Амарсанаа тухайн үед Эрүүл мэндийн дэд сайд байсан. Танилцуулгын дараа би Америк руу явсан. Тэнд Стэнфордын их сургуулийн төгсөгч Греиг Алтонтой танилцсан юм. Учир нь тэдний байгууллага элэгний С вирусийг эмчлэх эм гаргаснаа танилцуулсан байсан нь миний сонирхлыг асар их татсан л даа. С вирусийг эмчлэх софосбувир эм гурван сарын курс нь 900 ам.доллар байсан. Ж.Амарсанаа над руу яриад би наана чинь нэг хуралд оролцохоор боллоо. Тэгэнгээ С вирусийн эм үйлдвэрлэж буй компанийн чинь хүмүүстэй уулзъя гэсэн. Би америкчууддаа “Манай дэд сайд ирэх нь, хувийн элэгний эмнэлэгтэй, хамтран ажиллах боломж бидэнд байна” гэж маш их найдлага тээж танилцуулсан. Ингээд Ж.Амарсанаа ирсэн. Бид маргааш нь компанитай танилцуулсан. Гэтэл тэр уулзалт, танилцуулгууд дээр Ж.Амарсанаа нэг их юм ярьж өгөхгүй, нэг л хайнга, үл тоомсорлосон байдалтай яваад байсан. Уулзалтын дараа тухайн үед Сан-Францискогийн Ерөнхий консул байсан Ц.Анхбаяр гарч ирээд “Гурван сарын курс эмчилгээ нь 900 ам.доллар гэдэг чинь гайгүй үнэ юм биш үү” гэж ярьж байхад Ж.Амарсанаа хажууд зогсч байсан. Тэр үед Харвони гэж уудаг эм бас гарч байгаа тухай яригдаж байсан үе. Орой нь зочид буудалд нь хургаж өгөөд гадаа нь жаахан юм ярьж суугал Ж.Амарсанаа “Би энэ эмийг маш том бизнес гэж харж байна. Чи надтай хамтраад энэ бизнесийг хий. Ашгийн 80 хувийг нь би авъя, 20 хувийг нь чи ав. Би өвчтэй хүмүүсийн мэдээллийг ХӨСҮГ дээр ч юм уу цуглуулаад нэгдсэн байдлаар оруулж ирнэ” гэсэн. Тэгэхээр нь би “900 ам.доллар дээр таван ам.доллар нэмсэн ч манай ард түмэн үнийг нь дийлэхгүй шүү дээ. Харин ч Турк зэрэг олон орон шиг улс нь худалдаж аваад иргэддээ үнэ төлбөргүй тараах ёстой. Тэгээд ч энэ бол гурвалсан эмчилгээтэй эм. Дан ганц софосбувир эмийг уухгүй. Цаана дахин эм, тариа хоёр хавсарч хэрэглэх ёстой. Зөвхөн нэг тариа нь 220 ам.долларын үнэтэй. Гурван сарын эмчилгээ нь 5000 орчим ам.доллар болно. Чи төрийн сайд хийгээд явж байж ийм юм ярьж байгаа бол би чамаар энэ ажлыг хийлгэхгүй” гэсэн. Ж.Амарсанаа “Чи юу гэж хүний бизнесийг булаагаад байгаа юм. Чи ер нь юу хийсэн юм бэ?” гэж давшилсан. Ингэж бид хоёр жаахан онцгүй салсан. Өглөө нь над руу уучлал гуйсан мессэж явуулсан байсан. Одоо ч надад тэр мессэж нь бий. Нөгөөдөр нь Монголоос мэдээний линк ирснийг харгал Ж.Амарсанаа хэвлэлийн бага хурал хийгээд элэгний С вирусийг эмчлэх эм 1800 ам.доллараар оруулж ирэх гэж байгаа тухайгаа ярьсан байсан. Би мэл гайхсан. Юун 1800 ам.доллар вэ. Ерөнхий консул Ц.Анхбаярыг “900 ам.доллар чинь гайгүй үнэтэй юм биш үү” гэж хэлэхэд хажууд зогсож байсан хүн. Мань хүн яг буруу ойлгож гээд, би бизнес хийх гэж зориуд тэгж ярьсанд нь огт итгээгүй юм. Бид Ерөнхийлөгчөөс өгсүүлээд уулзсан бүх сайд, дарга нарт “900 ам.долларын эмийг энэ дэд сайд чинь будиулаад байна шүү” гэдгийг хэлээд явсан учраас Ж.Амарсанаа нэг л өдөр үнэнд гүйцэгдсэн л дээ. В вирусийн тенофовир гэж Америкт зургаан ам.доллараар зардаг эмийг “Хаши веритас” 225 мянган төгрөгөөр зарж байсан. Бид уг эмийг үйлдвэрлэдэг Mylan компанитай холбоо тогтоогоод “Танай дистрибьютер компани чинь энэ эмийг хэт өндөр үнээр дамлаж байна. Та нар үүнийгээ боллуулаач” гэж хэлсэн. Одоо “Эм импекс” компани дээр энэ эмийг 25 мянган төгрөгөөр зарж байгаа. Гэтэл Ж.Амарсанаа “Би Азийн олон улсын байгууллагатай ярьж байгаад үнийг нь буурууллаа. Одоо та энэ эмийг уухын тулд 400 хэдэн мянган төгрөгийн шинжилгээнд хамрагдсан байх ёстой” гээд хэвлэлээр шуудаад эхэлсэн. Ж.Амарсанаа намайг тас цохиж хэзээ ч чадахгүй.

### Сэтгүүлчийн дүгнэлт

## ӨВЧТЭЙ НЭГЭНД БУЯН ХИЙСНЭЭ ӨМЧЛӨХ ХЭРЭГ БАЙНА УУ


Б.ЭРХЭС

Гуравхан сая хүн амтай атлаа элэгний өвчлөл, хорт хавдрын нас баралтаар дэлхийд тэргүүлж буй монголчуудын хувьд Харвони гэх “шидэт” эмийг оруулж ирэх тухай яриа ёстой л бүрхэж тэнгэрээс нар гарах шиг сайхан мэдээ байсан. Эрс тэрс уур амьсгалтай илэж буй хоол хүнснээсээ эхлээд эрүүл хэв маягийг баримталж сураагүй бидний хувьд хамгийн дотны хүнээ өвдөж, элэгний хортой, хоргүй хавдрын улмаас шаналж буйг харах хэцүү байдаг Тиймдээ ч монголчуудын толгойн өвчин болоод буй энэ өвчинд хэрэгтэй, ач тустай л гэвэл “баас” байсан ч өөртөө болон ар гэрийнхэндээ худалдаж авч өгөхөд бэлэн байгаа нь худлаа биш. Гэтэл бидний энэ арчаагүй байдал бусдад буруу ойлголт өгч бизнес хийх санал сэдэл төрүүлсэн бол харамсалтай гэхээс өөр хэлэх үг алга. Ж.Амарсанааг элэгний өвчлөлийн талаар салбартаа л хүлээн зөвшөөрөгдсөн нэгэн гэдгийг бүгд мэднэ. Дэд сайд байхдаа энэ эмийг оруулж ирэх талаар анх олон нийтэд зарлаж, олон ч хүний талархлыг хүлээсэн.

Хэвлэл мэдээллийн бид ч элэгний С вирусийг эмчлэх эм Монголд орж ирэх нь, энэ вирус идэвхжсэн хүн бүхний хувьд сайхан мэдээ дуудлаа хэмээн баярлаж чадах чинээндээ л дэмжиж бичиж байв. Д.Наранбаатар гэгчийн дүгнээд байгаа шиг Ж.Амарсанаад хайртай дуртай, түүний талд ажилладаг учраас ч дэмжсэн зүйл үгүй. С вирусээ бүрэн устгах гэж гадаад дотоод явж хэдэн мянган ам.доллар урж байсан хүмүүс ч Монголдоо энэ эмийг авч ууна гэдэг сайхан мэдээ байлаа. Гэтэл эмийг оруулж ирсэн, ирээгүй гэх маргаан “ОНОМ” сангийн тэргүүн Д.Наранбаатар, Ж.Амарсанаа дэд сайд хоёрын дунд гарч, ийн иргэдийг үл итгэх, эргэлзэх байдалд оруулж орхив. Үнэхээр дэлхийн олон оронд дааж давшгүй үнэтэй байсан эмийг Монголд хямд үнээр оруулж ирээд даатгалд хамруулж хямд үнээр зарж байна уу, эсвэл Д.Наранбаатарын хэлсэнчлэн 900 ам.долларын эмийг дамлаж 1800 ам.доллар гэж яриад явсан уу гэдгийг ялгаж салгах цаг нь болсон мэт санагдана. Харвони эм анх орж ирэхдээ л хэл ам, хэрүүл тэмцэл дагуулсан.

Салбарын хоёр сайд болох сайд Н.Удвал, дэд сайд Ж.Амарсанаа нарын дунд маргаан дагуулж, улмаар хэнийх нь зөв байсан нь өнөө хэр шийдэгдээгүй явж байгаа. Гэтэл ганц эм оруулж ирсэн асуудлаар дахиад л хоёр өөр тал гарч ирнэхэд би оруулсан, чи хулгай хийсэн, худлаа ярьсан гэж хэрэлдээд эхлэхээр энэ эмийг чинь итгэж уух хүн олдхо уу. Эцсийн эцэст элэгний эм хоёрхон хүний өмчлөх асуудал биш байлтай. Хэн анх санаачилж оруулж ирсэн нь тэгтлээ чухал сэдэв биш. Тэгээд ч хоёулаа л ард түмний эрүүл мэнд, сайн сайхны төлөө оруулж ирсэн бол одоо энэ хөгийн явуургүй үйлдлээ таслан зогсоох цаг нь болсон юм биш үү. Өвчтэй нэгэнд буян үйлдсэнээ хүртэл өмчлөх гэж хэрүүл хийж явах тийм чухал биш л баймаарсан, залуус аа. Юутай ч дэд сайд асны хувьд зүгээр байхад хүмүүс энэ мэтээр гүтгэж доромжлоод байхгүй гэдгийг мэдэж өөртөө ч гэсэн дүгнэлт хиймээр байгаа юм. Ард түмнийг үнэтэй эм гэх мэтээр хошгируулж, арай л дэндсэн үйлдэл хийсэн бол уучлалт гуйхад юуных нь буруу байхав. Д.Наранбаатар ч ялгаагүй Ж.Амарсанаа анх дуугарсаны дараа тэр гарч ирсэн үү гэвэл тийм. “ОНОМ” сан гэгч олонд чиглэсэн ямар үйл ажиллагаа явуулдаг вэ гэдгийг мэдэхгүй хүн ч олон бий.

Гэхдээ монголчуудын сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулж буй л бол сайхан нэр хүн, сайн ажлаа ийм жижигхэн асуудлаар баллуурдах хэрэг байна уу. Эцэст нь хэлэхэд энэ хоёр эрхэмд элэгний эмийг оруулж ирсэн, ирээгүйгээс өөр хийх ажил олон байгаа гэж итгэе. Харвони эмийг дагасан олон янзын таамаг ярига эцэслэж, төрөөс энэ эмийг иргэддээ үнэгүй олгох талаар хамтарч ажиллаад явахад юун болохгүй байх билээ. Элэгний өвчлөл эм оруулж ирснээр алга болчихсон зүйл огтхон ч алга. Тиймээс үнэхээр буян хийж, бусдад аз жаргал бэлэглэхийг хүсч байгаа бол явган хэрүүлээ орхиод өөр олон ажил хийхсэн. Залуус нэг нэгэндээ туньж, гомдож болно. Гэхдээ өвчний асуудал, тэр дундаа гадны нэг эмийг хэдэн төгрөгөөр хэн анх оруулж ирснээрээ маргах чинь үнэндээ ичмээр харагдаж байгааг хатуухан сануулчихъя. Харвони олон хүнд буян болж байгаа. Гэвч хар мөр дагуулсан хэл ам хэрүүл тэмцэл чинь энэ эмэнд үл итгэх байдал бий болгох вий.





# ДЭЛХИЙ

## Польшид цэргийн сургуулилт эхэллээ

Умард Атлантын цэргийн эвслийн "Анаконда" /Anakonda/ цэргийн сургуулилт өчигдөр Польш улсад эхэлжээ. Тус улсын Батлан хамгаалах яамны мэдээлснээр, 24 орны 31 мянган цэргийн албан хаагч, тэдний дотор Польшийн 12 мянган цэрэг, АНУ-ын 10 мянган цэрэг, Их Британийн 1000 орчим цэрэг энэ удаагийн хэерийн сургуульд оролцож байна. Польш улсын түүхэнд ийм өргөн хэмжээний сургуулилт анх удаага болж байгаа нь энэ ажээ. Польш дахь хэерийн сургуулийн бүх талбайд өрнөх уг сургуулилтад 3000 орчим нэгж цэргийн техник, 100 гаруй нисэх онгоц, нисдэг тэрэг болон 12 байлдааны хөлөг онгоц хамрагдан оролцож байна.

Польшийн Батлан хамгаалах яамны мэдээлснээр, энэ удаагийн сургуулилын гол зорилго нь үндэсний болон холбоотны хүчний командлалуудын үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлэх явдал юм. "Анаконда" сургуулилттай зэрэгцэн "Сэлэмний давчлалт" гэдэг сургуулилт мөн явагдах бөгөөд түүний явцад Герман болон Польшийн нутаг дэвсгэрээр дамжуулан цэргийн техник болон бие бүрэлдэхүүнийг Балтын тэнгисийн орнууд болон Румын болон Болгар руу шилжүүлэн зөөвөрлөх хувилбаруудыг туршиж ажээ. "Анаконда" цэргийн сургуулилыг 2006 оноос эхлэн хоёр жил тутам хийж байгаа бөгөөд 2012 оноос олон улсын хэмжээний хамтарсан хэерийн сургууль болон өргөжжээ. 2014 онд болсон "Анаконда"-д найман улсын 12.5 мянган цэргийн албан хаагч оролцож байв.



## Кейко Фужимори ПЕРУГИЙН СОНГУУЛЬД БҮДЭРЛЭЭ

Б.ДАВАА

Перугийн ард иргэд сүүлийн хоёр хоног сонгуулиар амьсгалж байна. Тус улсын дараагийн төрийн тэргүүнийг сонгох шийдвэрлэх сонгуулийн санал хураалт орон нутгийн цагаар өнгөрөгч ням гарагт болж, эцсийн дүн өчигдөр албан ёсоор зарлагдаж эхлэв. Эхний удаагийн санал хураалтаас хамгийн олон санал авсан Кейко Фужимори, Дэлхийн банкны эдийн засагч асан Педро Пабло нар тунаан үлдсэн бөгөөд тэдний хооронд энэ удаагийн сонгуулийн тулаан өрнөсөн юм. Эхний шатны санал хураалтад нийтдээ 10 нэр дэвшигч өрсөлдсөн. Гэвч нэр дэвшигчдийн хэн нь ч 50-нас илүү хувийн санал авч чадаагүй тул хамгийн олон хувийн санал авсан хоёр эрхмийн хооронд дахин сонгууль явагдсан нь энэ байв. Сонгуулийн сурталчилгаа эхэлсэн тэр мөчөөс Перугийн экс Ерөнхийлөгч Альберто Фужиморигийн охин Кейко Фужимори дэмжигчдийнхээ хувиар өрсөлдөгчөөсөө илт давуугаар тэргүүлж байсан юм. Түүнчлэн, эхний шатны санал хураалтад 33 хувийн санал авч бусад нэр дэвшигчдээсээ үнэмлэхүй ялалт байгуулж байв. Харин түүний өрсөлдөгч

...Ямартай ч, Кейко энэ удаа сонгогдсон бол Перугийн анхны эмэгтэй Ерөнхийлөгч болох байв. Эцгийгээ тус улсын төрийн тэргүүнээр ажиллаж байхад тэргүүн хатагтайн үүргийг гүйцэтгэж байсан гэх бүсгүйг эшгийнхээ улс төрийн бодлогыг үргэлжлүүлэн гэж хардах хүмүүс байсан...

Дэлхийн банкны эдийн засагч асан Педро Пабло ердөө 16 хувийн санал авч байжээ. Үүнээс гадна хэд хэдэн санал асуултад ч тус улсыг 10 жилийн турш тэргүүлсэн Альбертогийн охин ялах магадлал өндөртэй байсан билээ. Гэсэн ч, эцсийн дүндээ үр дүн эсрэг талд гарлаа. Перугийн Ерөнхийлөгчийн сонгуулийн шийдвэрлэх шатны санал тооллогын явц 80 хувьтай үргэлжилж байхад, Кейко Фужимори, Педро Пабло нар 1.64 хувийн зөрүүтэй саналыг авсан байсан нь дэлхийн хэвлэл мэдээллийн онцлох сэдвийн нэг байсан юм. Сонгуулийн ерөнхий хорооноос мэдээлснээр санал тооллогын явц 79.4 хувьтай байхад Педро Пабло 50.82, Кейко 49.18 хувийн санал авсан байжээ. Тэдний саналын зөрүү ердөө 1.64 бөгөөд өрсөлдөөн маш ширүүн явагдсан нь үүнээс тодорхой харагдаж байгаа юм. Кейко Фужимори нь Перу улсын ерөнхийлөгч

асан, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэнд буруутгагдан, эдүгээ шоронд хоригдож ял эдэлж байгаа Альберто Фужиморигийн охин юм. Тэрбээр гэмт хэргийн эсрэг тэмцэх явдлыг мөрийн хөтөлбөрийнхөө тэргүүн зорилт болгож, Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний шатны санал хураалтад нийт 10 нэр дэвшигчээс тэргүүн байранд тунасан. Түүнчлэн өчигдрийн санал хураалтаас өмнө ч Фужимори ялах магадлал илүү өндөртөйд тооцогдож байсан юм. Гэвч эдүгээ 77 настай Кучински хэт төвийг баримталсан байр сууриа орхиж, Фужиморигийн мөрийн хөтөлбөрийг нээлттэй шүүмжилснээр эцсийн мөчид байдлыг эргүүлж, өөртөө олон сонгогчийг татаж чадлаа гэж шинжээчид дүгнэж байна. Уолл Стритийн санхүүч асан Педро Пабло Кучинскигийн Ерөнхийлөгчөөр сонгогдох хамгийн гол шалтгаан нь банк санхүүгийн салбар дахь туршлага юм. Тэрбээр өөрийн туршлагаа ашиглаж, Перугийн эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэхээ амласан удаатай. Энэ хоёр нэр дэвшигчийн төлөө Перугийн 23 сая орчим иргэн санал өгөх эрхтэй байгаа ажээ. Ямартай ч, Кейко энэ удаа сонгогдсон бол Перугийн анхны эмэгтэй Ерөнхийлөгч болох байв. Эцгийгээ тус улсын төрийн тэргүүнээр ажиллаж байхад тэргүүн хатагтайн үүргийг гүйцэтгэж байсан гэх бүсгүйг эцгийнхээ улс төрийн бодлогыг үргэлжлүүлэн гэж хардах хүмүүс байсан. Гэхдээ энэ удаагийн сонгуульд ард иргэд экс Ерөнхийлөгчийн "үргэлжлэл"-ийг бус, санхүүгийн арвин туршлагатай эдийн засагч эрхмийг маш бага саналын зөрүүтэйгээр сонголоо.



## Турк эмэгтэйчүүд дор хаяж гурван хүүхэдтэй болох ёстой гэв

Туркийн Ерөнхийлөгч Ресеп Тайип Эрдоган өчигдөр эмэгтэйчүүдийн төрүүлэх хүүхдийн доод хязгаарыг тогтоосон нэн хачирхалтай мэдэгдлийг хийв. Тодруулбал, турк эмэгтэйчүүд багадаа гурван хүүхэд төрүүлэх ёстой гэдгийг онцолсон байна. Р.Эрдоган охиныхоо тэргүүлэх "Ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо"-ны шинэ барилгын шав тавих ёслолд оролцох үедээ дээрх мэдэгдлийг хийжээ. "Ээж болохоос татгалзана гэдэг эмэгтэй хүний жам ёсны амьдралаас татгалзаж байна гэсэн үг. Багаар бодоход гурван хүүхэдтэй байх ёстой. Ажил хийдэг гээд ээж болохоос татгалзаад байж болохгүй" хэмээжээ.

Мөн тэрбээр Турк улс ажил эрхэлдэг эхчүүд рүү чиглэсэн чухал арга хэмжээг бодлогын төвшинд авч хэрэгжүүлж ирсэн гэдгээ энэ үеэр онцолсон байна. Туркийн хүн ам сүүлийн жилүүдэд эрчимтэйгээр нэмэгдэж байгаа ч, хүн амаа өсгөх байр суурийг баримталдаг Ерөнхийлөгч Эрдоган өнгөрсөн хугацаанд ч гэсэн эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэх асуудалд хэд хэдэн удаа хачирхалтай мэдэгдлийг хийж байсан. Албан ёсны статистик мэдээллээр, Туркийн хүн ам 2000 онд 68 сая хүрэхтэй үгүйтэй байсан бол өнгөрсөн онд 78.741 сая хүртлээ өссөн үзүүлэлттэй байсан юм. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.3 хувиар өссөн үзүүлэлт байлаа.

## Оддын харш гал түймэрт өртөж болзошгүй

АНУ-ын Лос-Анжелес хотын зах хэсгийн уулархаг бүс нутагт хэерийн түймэр гарч, Ким Кардашьян тэргүүтэй барууны оддын тансаг харш өртөж магадгүй ноцтой нөхцөл байдал үүсээд буй ажээ. Одоогоор тансаг хороолол болох Калабасасын 5000 орчим оршин суугчид нь өнгөрсөн долоо хоногоос эхлэн нүүж эхэлсэн байна. Гал сөнөөгчдийн хэлж буйгаар түймэр 200 га газрыг хамран тархжээ. Одоогоор гал түймрийн 30 орчим хувийг унтраасан ч, гал унтраах ажиллагаа тухайн бүс нутагт үргэлжилж байгаа юм байна. Хамгийн сүүлд авсан мэдээллээр хоёр айлын орон сууц, нэг үйлдвэр шатсан гэсэн мэдээлэл байна. Азаар хүний амь нас үрэгдээгүй бөгөөд хоёр гал сөнөөгч гэмтсэн гэнэ. Малибугийн далайн эргийн байгалийн үзэсгэлэнд шунаж, Лос-Анжелес хотын зах хэсэг 30 хэм хүртэл халж, салхи үлээсний улмаас хэерийн түймэр хурдацтай тархаж, ард иргэдийг нь нүүлгэн шилжүүлэхээс өөр аргагүйд хүрээд байна. Калабасасын ороо орчимд поп дуучин Жессика Симпсон, Реалити шоу болох "Кардашьянхан"-ы эгч дүүсийн тансаг орд харш байрладаг ажээ.

## "Лалын улс" бүлэглэлд цаазлагдсан 400 хүнийг цогцсыг олжээ



Иракийн армийнхан Эль Фаллужа хотын орчмоос 400 орчим хүний цогцос бүхий бөөнөөр оршуулсан газрыг илрүүлсэн байна. Арми, цагдаа, аюулаас хамгаалах хүчнийхэн болон Хашед аль-Шааби гэдэг сайн дурын дайчдын нэгдсэн хүчин Эль-Фаллужа хотын ойролцоох Шухада дүүрэгт мина цэвэрлэх ажиллагаа явуулж байх үеэрээ томоохон хэмжээний оршуулгын газар байгааг илрүүлжээ. Иракийн Зэвсэгт хүчний алба хаагч болон энгийн иргэдийн 400 орчим тооны цогцос байна гэж Анбар мужийн цагдаагийн хурандаа мэдэгдэв.

Түүнчлэн тэдний ихэнх нь 2014-2015 онд хэт даврагч "Лалын улс" бүлэглэлийн дайчдад цаазлуулсан цэргүүдийн цогцос байсны зэрэгцээ хууль зөрчсөн, тагнуул хийсэн гэх шалтгаанаар цаазлуулсан энгийн иргэд мөн багцсан байжээ. Мөн албаныхны баталж буйгаар энэ удаа олдсон цогцоснуудын ихэнх нь толгойгоо таслуулсан байсан аж. Иракийн зэвсэгт хүчин өнгөрсөн сарын сүүлчээс эхлэн нийслэл Багдаад хотоос баруун тийш 50 орчим км-т орших Эль Фаллужа хотыг хэт даврагч бүлэглэлээс чөлөөлөх томоохон хэмжээний цэргийн ажиллагааг эхлүүлсэн юм.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендер шалгаруулалтын нэр:** Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажил.  
**Тендер шалгаруулалтын дугаар:** ЗАА-ИБХ-16/30

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах барилга угсралтын ажил гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг эрх бүхий тендерт оролцогчдыг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100.000 [нэг зуун мянган] төгрөгөөр худалдан авч болно.  
Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн хамт 1 488 000 [Нэг сая дөрвөн зуун наян найман мянган] төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн, 10 цаг-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Ц.Жигжиджавын гудамж-9, Нийслэлийн засаг захиргааны II байр, Хангарьд ордон, 602 тоот, Р.Даваасүрэн, Утас:31-54-29, 31-54-30

Төрийн сан банк: 200051008 Захирагчийн ажлын алба УБ хот НААТХэлтэс



# ШУУРХАЙ МЭДЭЭ

## УТАСГҮЙ ИНТЕРНЭТ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЙТААР ХЯЗГААРЛАГДАХГҮЙ

### Сурагчдын зуны амралт өнөөдөр эхэлнэ

**“Улаанбаатар хотыг утасгүй интернэтжүүлэх” төслийн талаар танилцуулахгүй юу?**

“Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн Мэдээллийн технологийн газар “Улаанбаатар хотыг утасгүй интернэтжүүлэх” төслийг хэрэгжүүлж байна. Энэ төсөл нь Улаанбаатар хотыг утасгүй интернэттэй болгох, иргэдэд төрийн үйлчилгээний талаархи мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилготой. Төслийн хүрээнд нийслэлийн есөн дүүргийн 151 хороо, Багахангай, Сонгинохайрхан, Налайх, Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр зэрэг нийт 155 байршилд утасгүй интернэтийн бүс бий болгон туршилтаар ажиллуулна. Энэ сардаа багтан 155 цэгт утасгүй интернэт байрлуулна.

**Утасгүй интернэтийн сүлжээнд иргэд гэрээсээ холбогдож болох уу?**

Үгүй. Бид хорооны байрнуудад утасгүйинтернэтийнWiFiтөхөөрөмж байрлуулна. Иргэд хотын үнэгүй, утасгүй интернэтэд холбогдохын тулд өөрт ойр байрлах хорооны байр орчимд WiFi дэмждэг төхөөрөмжөө ашиглан “UBWiFi” нэртэй сүлжээнд холбогдсоноор интернэтэд орох боломжтой.

**Тэгэхээр заавал хорооныхоо байранд очиж интернэтэд орох боломжтой гэсэн үг үү. WiFi төхөөрөмж нь хэдэн метрийн зайд сүлжээ барих вэ?**

Өөрт хамгийн ойр байрлах хороон дээрээ очиж утасгүй интернэт ашиглаж болно. WiFi төхөөрөмж 100 метрийн зайд сүлжээ барина.

Н.БАТЗАГА

*“Улаанбаатар хотыг утасгүй интернэтжүүлэх” төслийн нээлтийн үйл ажиллагаа өчигдөр Чингисийн талбайд боллоо. Төслийн нээлтэд НИТХ-ын дарга Д.Баттулга, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Ё.Гэрэлчулуун, нийслэлийн Мэдээллийн технологийн газрын дарга Б.Бат-Өлзий нар оролцсон. Энэ үеэр нийслэлийн Мэдээллийн технологийн газрын дарга Б.Бат-Өлзийгөөс төслийн талаар зарим зүйлийг тодрууллаа.*

**Утасгүй интернэтээр зөвхөн нийслэлийн мэдээг авах боломжтой юу. Фэйсбүүк, твиттер болон бусад сайтуудад хандаж болох уу?**

Утасгүй интернэтийн гол зорилго нь Улаанбаатар хотын болон алслагдсан дүүргийн иргэдийг дуртай цагтаа интернэтээр аялах боломжоор хангах юм. Тэгэхээр иргэд энэ сүлжээнд холбогдсоноор нийслэлийн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй авах www.ulaanbaatar.mn сайтад зочлох, “Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн иргэний цахим нэг цонх www.citizen.ulaanbaatar.mn, газар өмчлөлийн цахим систем, www.land.ulaanbaatar.mn, иргэдийн оролцоотой Улаанбаатар хотын газрын зураглалын нэгдсэн сан www.manaikhoroo.mn, өөрийн амьдарч буй хорооныхоо эрүүл аюулгүй байдлын индексийн талаар мэдээлэл авах боломжтой www.eabi.ub.gov.mn, нийслэлийн нээлттэй өгөгдлийн порталwww.data.ulaanbaatar.mn, авто тээврийн хэрэгслийн нэгдсэн систем

www.smartcar.mn зэрэг төрийн үйлчилгээний цахим сайтуудад өндөр хурдтайгаар холбогдож, төрийн үйлчилгээг авч болно. Мөн өөрийн хүссэн сайт, цахим хуудсанд хандаж, интернэтийн орчинд хүссэнээрээ аялах боломжтой. Утасгүй интернэт ганцхан төрийн үйлчилгээний мэдээллээр хязгаарлагдахгүй. Утасгүй интернэтжүүлэх төслийг хэрэгжүүлснээр Улаанбаатар хот дэлхийн өндөр хөгжилтэй хотуудын жишигт хүрсэн ухаалаг хот болоход нэг том алхам болж байна.

**Утасгүй интернэтийн сүлжээнд хэрхэн бүртгүүлэх вэ. Ямар нэгэн код бий юу?**

Интернэтийг ашиглахад ямар нэгэн код байхгүй. Утасгүй интернэт ашиглахдаа ухаалаг гар утас болон таблет ашиглаж байгаа бол гар утасныхаа settings цэс рүү орон WiFi-а асаах, компьютер ашиглаж байгаа бол password цэсэнд байрших WiFi-а асаах хэрэгтэй. Ингэснээр утасгүй интернэтийн сүлжээнд холбогдож нийслэлийн мэдээ мэдээллийн сайт гарчирэх юм. Тус сайгаас цагаарын

мэдээ, зурхай болон нийслэлээс хийж, хэрэгжүүлж байгаа ажлын талаархи мэдээ, мэдээллийг авна. Мөн нийслэлээс хэрэгжүүлж байгаа ажилтай холбоотой санал хүсэлт, өргөдөл гомдол байвал бичиж, өгч болно. Утасгүй интернэтийг ашиглахын тулд бүртгүүлсэн байх шаардлагатай. Бүртгүүлэхдээ www.ulaanbaatar.mn сайтын бүртгүүлэх хэсэг рүү орох ёстой. Ингэснээр бүртгэлийн мэдээлэл цуглуулах хуудас гарч ирнэ. Энэ хуудсанд регистрийн дугаар, эцэг эхийн нэр, оршин суугаа хаяг, харилцах утас, цахим шуудан, нууц үг зэрэг мэдээллүүдийг оруулснаар бүртгэл идэвхжиж утасгүй интернэт ашиглах эрхтэй болно. Хэрэв өмнө нь цахим газарөмчлөл, цахим зуслангийн газар өмчлөлд бүртгүүлэн хандаж байсан бол тухайн бүртгэлийн мэдээллийг ашиглан утасгүй интернэтэд нэвтрэн орох боломжтой.

**Энэ төсөл хэчнэн төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа вэ?**

Нийт нэг тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа. Өдөөгийн байдлаар Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх зэрэг дүүргүүдийн хороонд “UBWiFi”-аа суурилуулсан.

**Зарим утасгүй интернэт маш удаан байдаг. Интернэтийн хурдыг хэрхэн шийдсэн бэ?**

Энэхүү төсөл нийслэлийн есөн дүүргийн иргэдийн утасгүй интернэтээр хангах зорилготой. Тэгэхээр удаан байх, гацах гэсэн асуудал байхгүй. Хэрвээ утасгүй интернэттэй холбоотой ямар нэгэн асуудал, гомдол, санал байвал бидэнд хандаж болно.

Ерөнхий боловсролын сургуулийн 2015-2016 оны хичээлийн жилийн зуны амралт энэ сарын 7 буюу өнөөдрөөс эхэлж байна. Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас гаргасан хуваарь ёсоор хичээлийн жил энэ сарын 6-нд дуусна. Хоёр болон гуравдугаар улирлын амралтын хувьд нийслэлийн болон орон нутгийн сурагчдынх өөр, өөр байсан бол дөрөвдүгээр улирлын амралт орон даяар нэг өдөр эхлэх юм байна.

### 49 настай иргэн Туул голд осолджээ

Туул голд нэгэн иргэн осолдож, амиа алдсан байна. Тодруулбал, нийслэлийн Хан-Уул дүүргийн IV хорооны нутагт байрлах Яармагийн гүүрний баруун талаар урсах хөдсөрт 49 настай иргэн О осолджээ. Түүний цогцсыг нийслэлийн Аврах ангийн зургаан албан хаагч ажиллаж, голоос гаргаж тус дүүргийн цагдаагийн хэлтэст хүлээлгэн өгсөн байна. Энэ хэрэгтэй холбогдуулан иргэдийг сонор сэрэмжтэй байхын зэрэгцээ архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ голын усанд орохгүй байхыг анхааруулж байна. Мөн бага насны хүүхдийг ганцааранг нь хараа хяналтгүй голын ойролцоо явуулахгүй байхыг ч НОБГ-аас сэрэмжлүүлж байна.

### Ангийн захирагчдыг хоёр өрөө байраар шагналаа

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран “Монгол цэргийн жавхаа-2016” уралдааныг 4 дэх жилдээ амжилттай зохион байгуулсан. Энэ жилийн уралдааны тусгай байрт хурандаа С.Болдбаатар захирагчтай Зэвсэгт хүчний 150 дугаар анги, гутгаар байрт хурандаа Д.Гантөмөр захирагчтай Хилийн 0164 дүгээр анги, дэд байрт хурандаа Д.Өлзийбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 350 дугаар анги, тэргүүн байрт хурандаа Б.Хаш-Эрдэнэ захирагчтай Зэвсэгт хүчний 084 дүгээр анги тус тус шалгарсан юм. “Монгол цэргийн жавхаа-2016” уралдаанд анги, байгууллагаа чадварлаг удирдан амжилттай оролцож, шагналт байранд шалгарсан ангийн захирагч

нарыг уралдааны болзлын дагуу орон сууцаар шагнаж тухай Нийслэлийн Засаг даргын 2016 оны тавдугаар сарын 27-ны А/427 дугаар захирамж гарлаа. Тус захирамжид тэргүүн байрт шалгарсан Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн захирагч, хурандаа Батдэлгэрийн Хаш-Эрдэнэд Баянгол дүүргийн 4 дүгээр хороо, “Түвшин өргөө” хотхон 304 дүгээр байрны 2 тоот 2 өрөө (49,35м2), дэд байрт шалгарсан Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн захирагч, хурандаа Доржсүрэнгийн Өлзийбаярт Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хороо 21 хорооллын 23а байрны 95 тоот 2 өрөө (37,5м2), гутгаар байрт шалгарсан Хилийн 0164 дүгээр ангийн захирагч, хурандаа Дамдины Гантөмөрт Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо, 94 дүгээр байрны 81 тоот 1 өрөө (29,36м2) орон сууцаар тус тус шагналаа.

### Согтуу жолооч хүн дайрч хөнөөгөөд, орхин явжээ

Өнгөрсөн амралтын өдрүүдэд Улаанбаатар хотын Замын цагдаагийн газарт нийт 531 дуудлага хүлээн авчээ. Үүнд, зам тээврийн ослын 366 дуудлага бүртгэгдсэн байна. Мөн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 23 бүртгэгдэж, нэг хүн нас барж, 28 хүнд хонгон гэмтжээ. Түүнчлэн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд холбогдсон жолооч найм, явган зорчигч хоёр, зам тээврийн осолд дөрөв хүүхэд өртсөн байна. Харин согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 143 жолоочийг илрүүлж гарч болзошгүй осол хэргээс урьдчилан

сэргийлж ажиллажээ. Тухайлбал, Хайлаастын зам, Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны байрны урд замд Mark-2 маркийн авто машины жолооч Б нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон унадаг дугуй унаж явсан 34 настай эрэгтэй Б-г мөргөж, амь насыг нь хохироон хэргийн газрыг орхин явсан байна. Мөн Сүбаатар дүүргийн нутаг Дамбадаржаагийн зам, долдугаар гудамжны зүүн замд Porter маркийн авто машины жолооч Г нь явган зорчигч 06 настай эрэгтэй Б-г мөргөж гэмтээгээд хэргийн газрыг орхиж явжээ.

### Эрүүл мэндийн 39 байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцалжээ

Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/435 дугаар захирамжаар эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг зарим аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ. Тус захирамжийн дагуу тусгай зөвшөөрлийг хуулийн хүчинтэй хугацаанд сунгуулаагүй, эмнэлэг сувилал, эмийн сан зэрэг 39 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон аж.

Тайлан ирүүлээгүй эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг зогсоосон байна. Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан, татан буугдсан, тусгай зөвшөөрлийг хуулийн хүчинтэй хугацаанд сунгуулаагүй, эмнэлэг сувилал, эмийн сан зэрэг 39 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон аж.


### 25 хүүхдэд уруул, тагнайн сэтэрхийн хагалгаа үнэ төлбөргүй хийнэ



Манай улсын хэмжээнд уруул, тагнайн эмгэгтэй 1000 гаруй хүүхэд эмчийн хяналтад байдаг байна. Үүний 60 гаруй нь Хөвсгөл аймагт амьдардаг аж. Тэгвэл Тайваний Хүүхэд гэр бүлийг дэмжих сан, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Уруул тагнайн төрөлхийн эмгэг судлалын нийгэмлэгтэй хамтран “Хязгаар нутгийн

инээмсэглэл” төслийг Хөвсгөл аймагт хоёр дахь удаагаа хэрэгжүүлээд байгаа аж.Тодруулбал, тус аймагт өмнө нь 2013 онд хэрэгжиж байсан бөгөөд 45 хүүхдэд мэс засал хийсэн байна. Энэ жил төслийн хүрээнд уруул, тагнайн сэтэрхийн эмгэгтэй хүүхдүүдэд үзлэг оношилгоо хийж, 25 хүүхдэд үнэ төлбөргүй хагалгаа хийхээр болжээ.

PHOTO NEWS



Гэрлэ зургийн ГАРГУУЖИН

Дамбадаржаагийн уулзаараас Шаргамортын төмөрбетон гүүр-Хандгайт чиглэлийн 16.35 км иж бүрэн авто замыг өчигдөр ашиглалтад бүрэн хүлээлгэн өглөө. Замын ажлыг “Тэгшит плант” ХХК, “Эрдэнэ зам” ХХК-ийн түншлэл, “Төгс зам” ХХК, “Наранбулаг-Хан” ХХК, “Мотор сервис” ХХК, “Офис сервис” компани гүйцэтгэжээ. Мөн зам дагуу 51 цэгт автобусны буудал, 44 цэгт ус зайлуулах төмөрбетон хоолой, гадаргуугийн ус зайлуулах лоток, гэрэлтүүлэг хийж инженерийн олон с шийдлийг гаргасан байна.



### СЭРЭМЖЛҮҮЛЭГ

#### Явган зорчигчийг мөргөж, хөнөөжээ

Сүүлийн үед хөдөө, орон нутгийн замд зам тээврийн осол ихээр гарч байна. Тухайлбал, өнгөрсөн амралтын өдөр Ховд аймгийн Алтай сум, Барлаг багийн Тохойн дэвсгэрт гэх газар шороон замд Уаз-31512 маркийн Т жолоочтой авто машин онхолдож, жолооч 52 настай эрэгтэй Т нас баржээ. Мөн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Тавантолгойн уурхайн амны гэр гуанзны хажуу шороон замд Northbenz маркийн авто машины жолооч Э нь явган зорчигч 29 настай эрэгтэй Н-г мөргөж, хөнөөжээ. Тиймээс нийт жолооч нарыг анхаарал болгоомжтой байхыг ЗЦГ-аас анхааруулж байна.



# ЗАВСАРЛАГА

ОЛДЫН ЦАГ

## ЖЕЙКОБ ТРАМБЛЕ: “ӨРӨӨ” КИНОНД ТОГЛОСНООР МИНИЙ АМЬДРАЛ ӨӨРЧЛӨГДСӨН

Орчуулсан Б.ДАВАА

Ирланд эр Ленни Абрамсоны найруулсан “Өрөө” кино хамгийн бага зардлаар бүтсэн дэлгэцийн бүтээлүүдийн нэг. Эмма Донохьюийн романаар бүтсэн уг кинонд харгис гаж донтны гэр дэх бөөс эрээх зайгүй өрөөнд олон жилийг үдэж буй залуухан эмэгтэй, түүний хүү хоёрын тухай өгүүлэх аж. Умгар жижигхэн өрөөгөө бүх л дэлхий хэмээн төсөөлж өссөн бяцхан хүүдээ гаднах орчныг үзүүлэхийн төлөө тэмцэх Жой гэж бүсгүйн дүрийг бүтээсэн Бри Ларсон 88 дахь удаагийн Академи авардсын шилдэг гол дүрийн эмэгтэй жүжигчний шагналыг хүртсэн билээ. 26 настай Бри Ларсон, есөн настай Жейкоб Трамбле нар эх, хүүгийн дүрийг бүтээжээ. Ингээд киноны гол дүрүүдийн “cinematoday.jp” сайтад өгсөн ярилцлагыг орчуулан хүргэж байна.

-Зураг авалт эхлэхээс өмнө ч та хоёрыг нэлээд хугацаанд хамт байсан гэж сонссон юм байна?

**Бри Ларсон:** Бид зураг авалт эхлэхээс өмнө бараг нэг сар хамт амьдарсан. Тодорхой хэлбэл, гурван долоо хоног юм байна. Зочид буудлын нэг өрөөнд хамтдаа леги тоглож, “Мэлхий нинжа”-ны тухай ярилцах гэх мэтээр л цагийг өнгөрүүлж байсан. Дараа нь продакшн руугаа явж, дизайперын бидэнд зориулж авчирсан янз бүрийн зүйлсээр тоглоом хийдэг байлаа.

**Жейкоб:** Бид янз бүрийн тоглоом хийсэн шүү. 00-ын цаасны гол болох хатуу картонон цаасаар их бую хүртэл хийсэн.

**Бри:** Тэгээд бид өөрсдийн хийсэн тоглоом, зурсан зурагнуудаа “Өрөө”-дөө авчирч, ханандаа наасан хэрэг.

**Жейкоб:** Тийм шүү. Тэр өрөөнд байгаа бүх л зүйл бидний өөрсдийнхөө гараар хийсэн зүйлс байсан. Тийм болохоор яг л гэртээ байгаа юм шиг санагдсан.

-Тийм өрөөнд зураг авалт хийхэд ямар санагдаж байв. Их л давчуу байх шиг байсан?

**Жейкоб:** Бүгчим байсан. Санаж байна уу?

**Бри:** Тийм шүү. Маш бүгчим байсан. Өрөө маань зөвхөн бид хоёр л амьдрахаар жижигхэн хэдий ч зураг авалтын үед тэнд маш олон хүн амьдарч байсан. Зураглаач гээд зургуулаа байдаг байлаа.

**Жейкоб:** Үүнээс гадна том машинууд ч байсан

**Бри:** Тийм ээ. Камер ч гэсэн байсан болохоор үнэхээр хөл тавих зайгүй. Нэг удаа найруулагч Ленни Абрахамсон вантгай усан дотор ороод нуугдчихсан байсан.

-Байнга нэг өрөөн дотор түгжигдэж амьдарсан Жак хүү гадагш гарч, тэнгэр ширтэж буй хэсэг миний хамгийн дургтай үзэгдэл. Тэр хэсгийн зургийг авах үед дотроо юу төсөөлж байсан бэ?

**Жейкоб:** Тухайн үед би хамгийн анх ямар нэг зүйлийг харж байгаа юм шиг, надад зориулсан онцгой бэлгийг задлах үеийнх шигээ тийм сэтгэл хөдлөл гаргахыг хичээсэн. Тэнд Хбох байгаа юм шиг төсөөлсөн. /Инээв/

-Хамгийн хэцүү нь аль хэсэг байв?

**Жейкоб:** “Өрөөнөөс гардаг хэсэг хамгийн удаан үргэлжилдэг. Хивсэнд ороож ачааны машины тээшинд ачих үед миний хөл хөшчихсэн. Харилцан яриагүй ч, яах ёстойгоо бараг мартчихсан. Энэ хэсгийн маш олон удаа авсан болохоор хамгийн хэцүү нь байсан гэж бодож байна. Зураглаачид ч гэсэн хэцүү байсан байх.

-Академи авардсыг дурьдахгүй өнгөрч чадахгүй нь. Киноныхоо дүрээр шилдэг гол дүрийн эмэгтэйн шагналыг хүртсэнд баяр хүргэе.

**Бри:** Баярлалаа.

-Оскарын шагналыг хүртсэнээр таны амьдралд ямар өөрчлөлт гарсан бэ?

**Бри:** Сайн мэдэхгүй юм. Шагнал авсан тэр орой л маш олон хэвлэлд ярилцлага өгсөн. Дараа нь шинэ киноны зураг авалт дууссан болохоор Вьетнам руу ниссэн юм. Байгаль сайтай хөдөө газар руу явсан болохоор тэнд юу ч байгаагүй. Гагцхүү тариалангийн талбай л байсан. Хэн ч надтай харилцаагүй болохоор сайн хэлж мэдэхгүй юм.

-Жейкоб ч гэсэн хөтлөгч болоод Академи авардсын тайзнаа гарсан нь гайхалтай байсан шүү?

**Жейкоб:** Баярлалаа. Шагнал гардуулах хөгжилтэй байсан. Бри шагналаа авахдаа үйлж байсан шүү. “Өрөө” кино шилдэг уран бүтээл гэсэн шагналыг авч чадаагүй ч, гол дүрийн жүжигчин нь шилдэг байж чадсан. Би түүнийг тайзнаа гарч шагналаа гардан авахад үнэхээр бахархах сэтгэл төрж байсан. “Өрөө” кинонд тоглосноор миний амьдрал маш их өөрчлөгдсөн. Хамгийн анх “The Smurfs-2” кинонд хамгийн анх тоглож, хоёр ч уран бүтээлд дүр бүтээсэн ч хараахан олны танил болж чадаагүй. Харин одоо бол маш өндөр харайсан юм шиг санагдаж байна.



Улаанбаатарт:



Маргааш

Өдөр +26  
Шөнө +9



Нөгөөдөр

Өдөр +25  
Шөнө +9



Аргын тооллын: 2016 оны 6-р сарын 7, Мянгар гараг

Билгийн тооллын: Шинийн 3. Хоёр хар лэнгэтэй Цагаан бич одор

Наран ургах/шингэх: 06:06 - 21:43

Үс засуулбал: Эд, тал баялаг төгөөдөр болно



Тухайн өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд сэрэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, хараал, жатхыг буцаах, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, хур оруулах, дарханы үйлд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохойболтой. Хол газар яваар одогсоод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Балжиннямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд малтай баялаг төгс болно.

6-Р САРД МАНАЙ ДЭЛГЭЦНЭЭ

2016.6.01 Тун удахгүй 2016.6.10 2016.6.17 2016.6.10

Сэтгэл доргдлох хүчээр "City Slide" - ын нээлийг

ЭНЭ ЗУНЫ ХАМГИЙН УРТ КАЙФ

ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ ЭРТ ЗАХИАЛВАЛ ХАМГИЙН ХЯМД 3'000ТӨГ

WWW.CITYSLIDE.MN

Хөлбөмбөгийн талбайг гурван удаа тойрсонтой тэнцэх гайхалтай урт усан гулгуур "Скай Ресорт"-д нээлтээ хийсэн билээ. City Slide нь дэлхийн олон оронд зохион байгуулагддаг бөгөөд Монголд анх удаа энэ зун болж байна. Энэ зуныг сайхан дурсалттай өнгөрөөхийг хүсвэл City Slide-д заавал очоорой.

6 сарын 1-5 өдрүүдэд болох шоуны тасалбар худалдаанд гарч эхлсэн тул <http://www.cityslide.mn/index.php> -эс тасалбараа захиалаарай.